



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

15160 Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, Хуульчдын гудамж 13/1  
Утас: 321138, Факс: (976-11) 322936  
E-mail: info@nduz.gov.mn, http: nduz.gov.mn

2022.03.30 № 39

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**「 НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН 「  
ХОРООНЫ ДАРГА М.ОЮУНЧИМЭГ ТАНАА**


Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны системчилсэн үнэлгээний тайланг хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 54 хуудастай.

ДАРГА \_\_\_\_\_ А.АРИУНЗАЯА





**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМЧИЛСЭН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2022 он

**АГУУЛГА**

- 1. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭЛБЭР, ТӨРӨЛ**
- 2. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙХ БЭЛТГЭЛ АЖИЛ, ТӨЛӨВЛӨЛТ**
- 3. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
  - 3.1 Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт
  - 3.2 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа
    - 3.2.1 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын хэрэгжилт
    - 3.2.2 Нийгмийн даатгалын хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, Засгийн Газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт
  - 3.3 Үндсэн үйл ажиллагаа
    - 3.3.1 Нийгмийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл
    - 3.3.2 Нийгмийн даатгалын сангийн орлого
    - 3.3.3 Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт
    - 3.3.4 Нийгмийн даатгалын хамралт
    - 3.3.5 Нийгмийн даатгалын сангаас үзүүлж буй тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардал
    - 3.3.6 Мэдээлэл технологийн үйл ажиллагаа
    - 3.3.7 Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хөгжүүлэлт, хүртээмж
    - 3.3.8 Эмнэлэг, хөдөлмөрийн магадлал
    - 3.3.9 Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах
    - 3.3.10 Хяналт шалгалт
    - 3.3.11 Лавлах үйлчилгээ
    - 3.3.12 Гадаад харилцаа, хамтын ажиллагаа
  - 3.4 Дотоод үйл ажиллагаа
    - 3.4.1 Хүний нөөц
    - 3.4.2 Санхүү төсвийн үйл ажиллагаа
    - 3.4.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
- 4. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**
- 5. ЦААШДЫН БОДЛОГО, ЧИГЛЭЛ**
- 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН АКТЫН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**
- 7. УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНООС ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**



**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНУУ	Бүгд Найрамдах Унгар Улс
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
КЭХА	Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагч
МУ	Монгол Улс
НББХ	Нийгмийн бодлогын байнгын хороо
НД	Нийгмийн даатгал
НДБ	Нийгмийн даатгалын байгууллага
НДС	Нийгмийн даатгалын сан
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НББСШУБХ	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
СЯ	Сангийн яам
ТҮЦ	Төрийн үйлчилгээний цэг
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХТАО	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого
ХЧТА	Хөдөлмөрийн чадвар түр алдалт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭХМТК	Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах төв комисс



**ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

- Хүснэгт 1. Системчилсэн үнэлгээний бүдүүвч
- Хүснэгт 2. Системчилсэн үнэлгээ хийх төлөвлөгөө
- Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт
- Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн 2021 оны орлогын гүйцэтгэл
- Хүснэгт 5. Нийгмийн даатгалын сангийн 2021 оны зарлагын гүйцэтгэл
- Хүснэгт 6. Нийгмийн даатгалын сангийн 2021 онд зарцуулсан мөнгөн дүн, үйлчлүүлсэн хүний тоо
- Хүснэгт 7. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн
- Хүснэгт 8. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн
- Хүснэгт 9. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн
- Хүснэгт 10. Хяналт, шалгалтад хамрагдсан НДХ
- Хүснэгт 11. НДБ-ын албан хаагчдын нас, хүйсийн мэдээлэл
- Хүснэгт 12. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт
- Хүснэгт 13. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

**ГРАФИКИЙН ЖАГСААЛТ**


- График 1. Нийгмийн даатгалын байгууллагын бүтэц
- График 2. Нийгмийн даатгалын сангийн төсөв
- График 3. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц
- График 4. Нийгмийн даатгалын хамралт
- График 5. Тэтгэврийн зарлага
- График 6. Тэтгэвэр авагчдын бүтэц
- График 7. Тэтгэврийн доод болон дундаж хэмжээ
- График 8. Тэтгэмжийн зарлага
- График 9. ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага
- График 10. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн
- График 11. Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын албан тушаалын ангилал, тоо
- График 12. Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын Байнгын хорооны 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолын дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайланг Хууль зүйн яам /хуучин нэрээр/-наас боловсруулсан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу гаргаж, үнэлгээ хийсэн болно.

Хүснэгт 1. Системчилсэн үнэлгээний бүдүүвч



**НЭГ. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭЛБЭР, ТӨРӨЛ**

*Системчилсэн үнэлгээ хийх шалтгаан:*

Тухайн байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө санхүү оновчтой болсон, зорилгодоо хүрсэн эсэхийг тогтоох шаардлага гарсан.

*Системчилсэн үнэлгээний зорилго:*

Үнэлгээний зорилго нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж өөрийн тавьсан зорилгодоо ямар хэмжээнд хүрсэн байдлыг бүх талаар тодорхойлоход чиглэсэн болно.

*Системчилсэн үнэлгээний зорилт:*

Үнэлгээний зорилт нь байгууллагын дэвшүүлсэн зорилго, хөгжлийн үр ашиг, үр дүнтэй байдал, үр нөлөө болон тогтвортой байдлын уялдаа холбоо, хэрэгжилтийг тодорхойлж аль болох системтэй, бодит байдалд нийцсэн байдлаар төлөвлөсөн, хэрэгжиж буй болон хэрэгжсэн үйл ажиллагааг үнэлсэн болно.

*Системчилсэн үнэлгээний хэлбэр:*

Үнэлгээний хэлбэр нь хэрэгжсэн хөтөлбөр болон арга хэмжээнд өгөх хэрэгжилтийн үнэлгээ /ретроспектив/ болно.



*Системчилсэн үнэлгээний төрөл:*

Үнэлгээ нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгод ямар хэмжээнд хүрсэнийг тодорхойлоход чиглэх бөгөөд Системчилсэн үнэлгээ хийхдээ “Дотоодын буюу өөрийн байгууллагын үнэлгээ”-ний хэлбэрийг сонгож, дараах чиглэлээр үнэлгээ хийлээ. Үүнд:

- Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт.
- НДҮЗ-ийн үйл ажиллагаа.
- Үндсэн үйл ажиллагаа.
- Дотоод үйл ажиллагаа.

**ХОЁР. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙХ БЭЛТГЭЛ АЖИЛ, ТӨЛӨВЛӨЛТ**

Бэлтгэл, төлөвлөлтийн үе шатууд.

*Системчилсэн үнэлгээ хийх бэлэн байдлыг хангах:*

- Системчилсэн үнэлгээ хийх талаар НДЕГ-т НДҮЗ-ийн Ажлын албаны даргын албан бичгээр мэдэгдэж, бэлэн байдлыг хангуулах;
- Үнэлгээний багийг бүрдүүлэх.

*Үнэлгээнд оролцогч байгууллагуудын цар хүрээ:*

- НДҮЗ-ийн Ажлын алба;
- НДЕГ;
- ЭХМТК;
- Мэдээлэл технологийн төв;
- Нийслэлийн Нийгмийн даатгалын газар, дүүргүүдийн НДХ;
- Аймгийн НДХ;
- БНСУ дахь Нийгмийн хамгааллын төвийн Нийгмийн даатгалын тасаг

*Үнэлгээ хийх хугацаа:*

- 2022 оны 01, 02, 03 дугаар сарууд.

*Хөндлөнгийн ба өөрийн үнэлгээг сонгох:*

- Өөрийн үнэлгээ хийнэ.

*Үнэлгээний зорилго, хамрах хүрээг тодорхойлох:*

- Үнэлгээний зорилго, хамрах хүрээ нь байгууллагын бүх салбар нэгжийн хүрээнд үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгодоо ямар хэмжээнд хүрсэн байдлыг бүх талаар тодорхойлоход чиглэсэн болно.

Хүснэгт 2. Системчилсэн үнэлгээ хийх төлөвлөгөө

Хугацаа		1-р сар	2-р сар	3-р сар
<b>Хэрэгжүүлбэл зохих ажлууд</b>		→		
<b>Төлөвлөлтийн шат</b>	Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлсон уулзалт хийх	■		
	Үнэлгээний баг бүрдүүлэх		■	
	Үнэлгээний төлөвлөгөөг боловсруулах		■	
	Үнэлгээ хийх талаар НДЕГ-т албан бичиг хүргүүлэх			■
	Тайлан гаргаж өгөх НДЕГ-ын холбогдох мэргэжилтэнтэй уулзах		■	■
<b>Үнэлгээний шат</b>	Баримт бичигтэй танилцах			■
	Тайлангийн талаар тодруулга, асуулга авах			■
	Ярилцлага хийх			■
	Дүн шинжилгээ хийх			■
	Дүгнэлт гаргах			■
	Зөвлөмж бичих			■
	Тайланг гаргах			■
	НДҮЗ-ийн хуралдаанд танилцуулах			■
	УИХ-ын Нийгмийн бодлогын Байнгын Хороонд хүргүүлэх			■

## ГУРАВ. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

### 3.1 Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт

НДБ нь НДҮЗ, НД-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн НД-ын газар, хэлтэс, тасаг, БНСУ дахь салбар, НД-ын байцаагч, ажилтнаас бүрддэг.

НДҮЗ нь УИХ-аас томилогдсон Засгийн Газар, Даатгуулагч, Ажил олгогчийг төлөөлсөн тус бүр 3, нийт 9 гишүүнтэй.

НДҮЗ-ийн Ажлын алба нь УИХ-ын НББСШУБХ-ны 2018 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан 12 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулдаг.


Ажлын алба нь НДҮЗ-ийн гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад туслах чиг үүрэгтэй ажиллаж байна.



ЗГ-ын “Агентлаг байгуулах тухай” 2017 оны 344 дүгээр тогтоол, НДҮЗ-ийн 2018 оны 04 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, орон тоог батлах тухай” 2018 оны А/25 дугаар тушаалын дагуу нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага НДЕГ нь 6 газар, 5 хэлтэс, дэргэдээ 2 төвтэй, нийт 111 албан хаагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймаг, нийслэл, дүүргийн 31 газар, хэлтэст НД-ын бодлогын хэрэгжилтийг хангах, НД-ын үйлчилгээг иргэд даатгуулагчдад үзүүлэх чиг үүрэг бүхий 1313 албан хаагч, улсын байцаагчид ажиллаж байна.

График 1. НДБ-ын бүтэц





### **3.2 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа**

НДҮЗ нь тайлант хугацаанд төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг удирдлага болгож, Нийгмийн даатгалын тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд НД-ын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн НД-ын салбарыг нэгдсэн удирдлагаар хангаж, дэлхий нийтийг хамарсан КОВИД-19 цар тахлын үед ажил олгогч, даатгуулагчдын санхүүгийн хүндрэлийг шийдвэрлэх зорилгоор УИХ-аас баталсан Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажиллалаа.

#### **3.2.1 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын хэрэгжилт**

НДҮЗ нь 2021 онд нийт 9 удаа хуралдан холбогдох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 24 тогтоол батлан гаргасан. Эдгээр тогтоолуудаас “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам”, “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувиллын хувьсах зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай”, “Нэрийн дансны 2020 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай”, “Нэрийн дансны 2021 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” гэсэн нийтээр заавал дагаж мөрдүүлэх 5 тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэв.

#### ***Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журмыг шинэчлэн баталсан***

НДҮЗ-ийн 09 дүгээр тогтоолоор “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам”-ыг шинэчлэн баталж мөрдүүллээ. Энэхүү журмыг даатгуулагчаас ажилгүйдлийн тэтгэмж авахаар бүрдүүлдэг байсан өргөдөл, НД-ын дэвтэр, ажлаас халсан тухай шийдвэр, иргэний үнэмлэх, түүний хуулбар, ажилгүй болсноо Хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлсэн тухай мэдэгдэх хуудас зэрэг баримт бичгийг цахимжуулж, хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх зорилгоор шинэчилсэн. Журам батлагдсанаар жилд 22 мянган хүн цахимаар ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ шийдвэрлүүлж цаг хугацаа, зардал хэмнэх юм.

#### ***Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувиллын хувьсах зардлын хэмжээг 2 дахин нэмэгдүүлэв***

НДҮЗ-ийн 16 дугаар тогтоолоор ҮОМШӨ-ний даатгалын сангаас санхүүжих сувиллын хувьсах зардлын хэмжээг 30000 төгрөгөөс 60000 төгрөг болгон 2 дахин нэмэгдүүлж шинэчлэн тогтоолоо. Сүүлийн жилүүдэд бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ өсч ашиглалтын болон хэрэглээний зардлууд нэмэгдсэнтэй холбоотойгоор өмнө мөрдөгдөж байсан ор хоногийн зардал нь нэг иргэний сувилалд хэвтэн эмчлүүлэхэд гарах бодит зардалд хүрэхгүй байсан. Хувьсах зардлын хэмжээг нэмэгдүүлсэнээр ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын тусламж үйлчилгээний чанар стандарт улам сайжирч, сувилуулагчдын сэтгэл ханамж дээшилнэ.



***Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, батлагдсан төсвийг хуваарилахад баримтлах журмыг шинэчлэв***

НДҮЗ-ийн 10 дугаар тогтоолоор “Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, батлагдсан төсвийг хуваарилахад баримтлах журам”-ыг шинэчлэн баталлаа. Нийгмийн даатгалын тухай болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудад орсон нэмэлт өөрчлөлтүүд, НД-ын салбарын ажилтнууд, улсын байцаагчдаас гаргасан саналуудыг үндэслэн энэхүү журмыг шинэчлэн боловсруулсан бөгөөд НДС-ийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах зарчим, тавигдах шаардлага, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг боловсруулах, Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх, батлуулах үйл ажиллагааг бүхэлд нь зохицуулсан. НДС-ийн төсөв боловсруулахад сум, дүүргийн НД-ын байцаагчдаас эхлээд НД-ын бүх шатны байгууллагуудын гүйцэтгэх үүргийг тодорхой болгож өгөв.

***Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн хуваарьт 2 удаа өөрчлөлт оруулж, 2022 оны төсвийн хуваарийг батлав***

НДҮЗ-ийн 11, 22 дугаар тогтоолуудаар Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Сангийн сайдын “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 192 дугаар тушаалыг үндэслэн 2021 оны НДС-ийн болон аймаг, дүүргийн НДС-ийн төсвийн хуваарьт 2 удаа холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, батлан мөрдүүлэв. НДҮЗ-ийн 23 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн дагуу НДС-ийн болон аймаг, дүүргийн НДС-ийн 2022 оны төсвийн хуваарийг баталж хүргүүлээ.

***Даатгуулагчдын нэрийн дансны 2021 оны орлогод тооцох хүүгийн хэмжээ, тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг тогтоолоо***

НДҮЗ-ийн 20, 21 дүгээр тогтоолуудаар Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, НДҮЗ-ийн 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан “Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох журам”, ҮСХ-оос ирүүлсэн саналыг үндэслэн даатгуулагчдын нэрийн дансны 2021 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 11.6 хувиар тогтоож, өндөр насны тэтгэвэр тогтоолгоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”)-ийг 2022-2024 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жил байхаар шийдвэрлэлээ.

***Капитал банкны өр төлбөр барагдуулах ажлын хүрээнд***

Капитал банкнаас НДС-д төлөх төлбөрийг барагдуулахтай холбоотой асуудлуудыг шуурхай хэлэлцэж шийдвэрлэн, 4 тогтоол батлан гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллалаа.

НДҮЗ-ийн “Өр төлбөр барагдуулах тухай” 02, 19, 24 дүгээр тогтоолуудаар КЭХА-аас нэхэмжилсэн сангийн төлбөрт хөрөнгө тооцон авах зөвшөөрөл олгож, холбогдох арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг НДЕГ-т үүрэг болгов. НДҮЗ-ийн 18 дугаар тогтоолоор “Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг



хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам"-ыг батлан мөрдүүлээ. Ингэснээр НДС-ийн авлага, өр төлбөрт үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, шаардлагатай зардлын төсвийг төлөвлөх, батлуулах, түрээслүүлэх, хөрөнгийг худалдан борлуулах, эргэлтийн хөрөнгөөр бүртгэсэн хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд худалдан борлуулах, түрээслүүлэх, НДБ-ын үйл ажиллагаанд ашиглах замаар сангийн авлагыг бууруулах, барагдуулах, мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэх боломжтой болсон. КЭХА-аас НДС-д 2020 онд 826.7 сая, 2021 онд 7,223.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, мөн 22,156.6 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгө хүлээн авч, нийт 30,206.6 сая төгрөгийн төлбөрийг барагдуулаад байна.

### **3.2.2 Нийгмийн даатгалын хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, Засгийн Газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт**

#### ***Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-д өргөн барилаа***

НД-ын багц хуулийн төсөл, үзэл баримтлалын шинэчлэлийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн бариад байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд НД-ын тогтолцоо, зарчим, төрөл, хэлбэр, хамрах хүрээ, НД-ын шимтгэл төлөх, сан бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, хуримтлагдсан орлогыг өвлүүлэх зохицуулалтуудыг оруулсан. Мөн НДС-ийн хөрөнгийн удирдлагад эрс шинэчлэлт хийх, эрсдлийн үнэлгээний мэргэшсэн хороо, ажилтнуудтай байх, сангийн удирдлагад эхний ээлжинд аюулгүй найдвартай байлгах, төлбөр түргэн төлөгдөх-хөрвөх чадвартай байлгах, эдгээр зарчмууд хангагдсан тохиолдолд үр ашиг, өгөөжтэй байх олон улсын жишигт нийцсэн зарчмаар удирдан зохицуулж, өнөөдөр үүсээд байгаа өрийн хүндрэлүүдийг дахин давтахгүй, гаргахгүй байхаар боловсруулаад байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, ахмад настан бүрт суурь тэтгэвэр олгох, иргэн бүр сайн дурын үндсэн дээр хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд даатгуулж, нэмэгдэл тэтгэвэр авах, тэтгэврийг индексжүүлэн нэмэгдүүлэх, хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд шилжих асуудлуудыг тусгалаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөлд ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх, донор болсон даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсан, ихэр хүүхэд төрүүлсэн эхийн амаржсаны тэтгэмжийн хэмжээг тус тус нэмэгдүүлэх, ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг ОУХБ-ын стандартад нийцүүлэх, ажил олгогчид 3 жилд нэг удаа 15 хувиар шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхээр зохицуулсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төсөлд урьдчилан



сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөрийг нэмэгдүүлэх, даатгуулагчийн протез, ортопедын үнийг 3 жил тутамд 1 удаа бүтэн чөлөөлөх, үйлдвэрлэлийн осол гаргаагүй ажил олгогчид 15 хувиар шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх, үйлчилгээг цахимжуулах асуудлууд тусгагдсан.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд МУ-д анх удаа хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, ахмад настнууд ирээдүйд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах, хангалттай орлогын эх үүсвэртэй байх боломжийг олгохоор зохицуулав.

***Ковид-19 цар тахлын үед аж ахуйн нэгж, даатгуулагчдийг НД-ын шимтгэлээс чөлөөлж, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх ажлыг 2021 онд үргэлжлүүлэв***

УИХ-аас хуульд 2020 оны 11 дүгээр сарын 13-ний өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу 38.9 мянган ажил олгогч, 410.7 мянган албан журмын даатгуулагч, 169.2 мянган сайн дурын даатгуулагчдад нийтдээ 873.9 тэрбум төгрөгийн НД-ын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн. Мөн ажилгүйдлийн даатгалын сангаас 7.3 мянган ажил олгогчийн давхардсан тоогоор 80.9 мянган даатгуулагчид 44.1 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

***Тэтгэврийн зээл аваагүй ахмадуудад 1 сая төгрөгийн үнэт цаасыг мөнгөжүүлэн олгож, 1 сая хүртэлх төгрөгийн тэтгэврийн зээлтэй ахмадуудын зээлийг тэглэв***

Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу тэтгэврийн зээлгүй болон 1 сая хүртэлх төгрөгийн тэтгэврийн зээлтэй тэтгэвэр авагч 229277 иргэнд 207.5 тэрбум, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш нас барж, үнэт цаасыг ар гэрийн хүнд нь өвлүүлсэн 5043 иргэнд 4.7 тэрбум, нийт 234320 иргэнд 212.2 тэрбум төгрөгийг 2021 онд олгосон.

***Тэтгэврийн даатгалын шимтгэлийг багасгав***

УИХ-аас 2021 оны 06 дугаар сарын 11-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг ажил олгогч, даатгуулагч 9.5 байсныг 8.5 хувь, сайн дураар даатгуулагч 12.5 байсныг 11.5 хувиар төлөхөөр болж тус бүр нэг хувиар буурууллаа. Ингэснээр бүх ажил олгогч болон даатгуулагчид тэтгэврийн даатгалын шимтгэлээ 8.5 хувиар жигд төлөх бөгөөд хуулийн өөрчлөлтөд нийт 49.7 мянган ажил олгогч, 168 мянган даатгуулагч хамрагдаж НД-ын шимтгэлийг бууруулснаар НДС-д төсвөөс үзүүлэх дэмжлэг нь 2021 онд 94.5 тэрбум, 2022 онд 198.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

***Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэв***

“Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль”, ЗГ-ын 2019 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг



нөхөн төлүүлэх журам"-ын дагуу тайлангийн хугацаанд 31.8 мянган малчин, 2.6 мянган хувиараа хөдөлмөр эрхлэгч, нийтдээ 34.4 мянган хүн 76.4 тэрбум төгрөгийн тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлж, шимтгэл нөхөн төлсөн дээрх иргэдээс 11.9 мянган иргэн шинээр тэтгэвэр тогтоолгон, тэдгээрийн тэтгэвэрт 33.0 тэрбум төгрөг зарцуулаад байна.

### 3.3 Үндсэн үйл ажиллагаа

НДҮЗ нь 2021 онд НД-ын хууль тогтоомжид заасны дагуу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

- НД-ын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, НД-ын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, НДС-ийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах;

- НДС-ийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, НДС-ийн хуримтлал бий болгох, гүйцэтгэлийг тайлагнах;

- НД-ын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

- НД-ын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон НД-ын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах;

- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, НД-ын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах;

- НД-ын үйлчилгээг цахимжуулах, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх;

- БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа МУ-ын иргэдийг НД-ын талаарх мэдээллээр хангах, тэтгэврийн даатгалд хамруулах, төлсөн шимтгэлийг бүртгэх, тэтгэврийн даатгалын сан бүрдүүлэх, төвлөрүүлэх, шимтгэлийн буцаан олголтыг холбогдох журмын дагуу зохион байгуулах болно.

#### 3.3.1 Нийгмийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл

Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд 2,398.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталсан. Үүнд:

- НД-ын шимтгэлийн орлого 1,803.7 тэрбум төгрөг;
- ЭМДС-аас санхүүжих 1.1 тэрбум төгрөг;




- улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 593.9 тэрбум төгрөгөөр баталсан.

Нийт зарлага 2,594.3 тэрбум төгрөг. Үүнд:

- тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардалд 2,567.2 тэрбум төгрөг;
- НД-ын байгууллагын үйл ажиллагааны зардалд 27.1 тэрбум төгрөг зарцуулахаар тус тус баталсан.


График 2. НДС-ийн төсөв /тэрбум.төг/



### 3.3.2 НДС-ийн орлого

НДС-д 2021 онд шимтгэлийн орлого 1,803.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2,137.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 118.5 хувиар биелүүлсэн. /энэ дүнд ЭМДС-аас санхүүжих 1.1 тэрбум, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 593.9 тэрбум төгрөг ороогүй/

График 3. НДС-ийн орлогын бүтэц /хувиар/



НДС-ийн нийт орлогын 53.1 хувь буюу 1,133.9 тэрбум төгрөгийг ажил олгогч, 46.5 хувь буюу 994.7 тэрбум төгрөгийг даатгуулагчийн төлсөн шимтгэл, 0.4 хувь буюу 8.4 тэрбум төгрөгийг ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн шимтгэлийн орлого болон бусад орлого эзэлж байна.



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хүснэгт 3. НДС-ийн орлогын биелэлт /тэрбум.төг/

№	Орлогын төрөл	2020	2021
1	Улсын төсвөөс олгох дэмжлэг	399.5	593.9
2	Ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагаас	463.6	790.4
3	Төсөвт газраас	290.1	343.4
4	Даатгуулагчаас	522.9	854.6
5	Сайн дурын даатгуулагчаас	138.0	137.6
6	Гадаадад ажиллаж буй иргэдийн	2.8	2.6
7	ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн	1.6	1.7
8	ЭМДС-аас санхүүжих	1.1	1.1
9	Бусад орлого	58.6	6.7
<b>Нийт</b>		<b>1,878.2</b>	<b>2,732.0</b>

Мөн орлогын 27.8 хувь буюу 593.9 тэрбум төгрөгийг тэтгэврийн болон ҮОМШӨ-ний даатгалын санд улсын төсвөөс, 0.05 хувь буюу 1.1 тэрбум төгрөгийг ЭМДС-аас шилжүүлсэн санхүүжилтийн орлого тус тус эзэлж байна.

Бусад орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.7 дахин буурсан нь НДС-ийн чөлөөт мөнгөн хөрөнгийг арилжааны банкинд хадгалуулж хүүгийн орлого олоогүй, КОВИД-19 цар тахлын үед эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор НД-тай холбоотой алданги, торгууль ноогдуулаагүйтэй холбоотой.

Хүснэгт 4. НДС-ийн 2021 оны орлогын гүйцэтгэл

№	Орлого	Мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	Нийт орлогод эзлэх хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	2,360.7	86.4
2	Тэтгэмжийн даатгалын сан	180.1	6.6
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	129.2	4.7
4	Ажилгүйдлийн даатгалын сан	62.0	2.3
<b>Нийт</b>		<b>2,732.0</b>	<b>100</b>

### 3.3.3 Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт

НДС-ийн зардлын төсөв 2,594.3 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд 2,565.5 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт, 26.6 тэрбум төгрөгийг НДБ-ын үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулсан.

Хүснэгт 5. НДС-ийн 2021 оны зарлагын гүйцэтгэл

№	Зардал	Мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	Нийт зардалд эзлэх хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	2,281.8	89.0
2	Тэтгэмжийн даатгалын сан	169.4	6.6
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	30.7	1.2
4	Ажилгүйдлийн даатгалын сан	57.0	2.2
5	Үйл ажиллагааны зардал	26.6	1.0
<b>Нийт</b>		<b>2,565.5</b>	<b>100.0</b>

НДС-ийн зарлага өмнөх оны мөн үеэс 113.7 тэрбум төгрөг буюу 4.4 хувиар өссөн.




Хүснэгт 6. НДС-ийн 2021 онд зарцуулсан мөнгөн дүн, үйлчлүүлсэн хүний тоо /мян.хүн, тэрбум.төг/

№	Нийгмийн даатгалын сан	2019 он		2020 он		2021 он	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Тэтгэврийн	412.9	1,839.2	437.1	2,153.6	455.5	2,281.8
2	Тэтгэмжийн	210.3	124.1	191.2	145.4	364.5	169.4
3	ҮОМШӨ-ний	8.7	30.8	7.6	31.6	5.7	30.7
4	Ажилгүйдлийн	23.1	43.6	21.3	94.4	26.2	57.0
5	Үйл ажиллагааны зардал		24.5		26.8		26.6
<b>Нийт</b>		<b>655.0</b>	<b>2,062.2</b>	<b>657.2</b>	<b>2,451.8</b>	<b>851.9</b>	<b>2,565.5</b>

НДС-аар үйлчлүүлсэн иргэдийн тоо өмнөх оныхоос 194.7 мянга буюу 22.8 хувиар өссөн бол НДС-ын үйл ажиллагааны зардал 0.2 тэрбум төгрөг буюу 0.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

### 3.3.4 Нийгмийн даатгалын хамралт

График 4. НД-ын хамралт /мян.хүн/



НД-ын мэдээллийн санд 2021 оны жилийн эцсийн байдлаар 52.7 мянган ААНБ бүртгэгдсэн нь 2020 онтой харьцуулахад 3.4 мянган ажил олгогч буюу 6.5 хувиар нэмэгдсэн.

Мөн албан журмын болон сайн дурын даатгалд 1,177.8 мянган даатгуулагч хамрагдсан нь нийт ажиллах хүчний 96.0 хувийг эзэлж байна. ҮСХ-ны 2021 оны 4-р улирлын тоон мэдээгээр нийт ажиллах хүчний тоо 1,226.5 мянган хүн/



**3.3.5 Нийгмийн даатгалын сангаас үзүүлж буй тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардал**

**Тэтгэврийн даатгалын сан**


2021 онд тэтгэврийн даатгалын сангаас нийт 455.5 мянган иргэнд 2.3 их наяд төгрөгийн тэтгэвэр олгосон. Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө буюу 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон 49.3 мянган тэтгэвэр авагч, 19.7 мянган цэргийн албан хаагчдын тэтгэвэрт 379.0 тэрбум төгрөг зарцуулсан.

Хүснэгт 7. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мянган хүн, тэрбум.төг/

№	Тэтгэврийн төрөл	2019 он		2020 он		2021 он	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Өндөр насны	307.5	1,396.9	332.9	1,663.9	353.2	1,789.6
2	Тахир дутуугийн	67.0	230.9	65.9	255.8	63.1	247.7
3	Тэжээгчээ алдсаны	19.8	70.1	19.2	77.6	19.5	77.1
4	Цэргийн	18.6	139.4	19.1	153.7	19.7	162.7
<b>Нийт</b>		<b>412.9</b>	<b>1,837.3*</b>	<b>437.1</b>	<b>2,151.0*</b>	<b>455.5</b>	<b>2,277.1*</b>

\* Бусад зардал ороогүй болно.

График 5. Тэтгэврийн зарлага /тэрбум.төг/



Тэтгэврийн даатгалын зардал өмнөх оноос 126.1 тэрбум төгрөг буюу 5.5 хувиар өссөн.



График 6. Тэтгэвэр авагчдын бүтэц /хувиар/

Нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 7.7 хувь нь хувь тэнцүүлсэн тэтгэвэр, 92.3 хувь нь бүрэн тэтгэвэр авч байна.



2021 оны байдлаар НДС-аас олгож буй бүрэн тэтгэврийн доод хэмжээ 350.0 мянган төгрөг байгаа нь амьжиргааны доод түвшингээс 46.6 хувиар илүү байна. /ҮСХ-ны мэдээллээр 2021 оны Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны доод түвшин сарын 238.7 мянган төгрөг/

График 7. Тэтгэврийн доод болон дундаж хэмжээ /мян.төг/



Улсын хэмжээгээр дундаж тэтгэврийн хэмжээ өмнөх оноос 1.5 хувиар өссөн.

**Тэтгэмжийн даатгалын сан**

Тэтгэмжийн даатгалын сангаас 364.5 мянган даатгуулагчдад 169.1 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгожээ.


Хүснэгт 8. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/

№	Тэтгэмжийн төрөл	2019 он		2020 он		2021 он	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	132.9	19.8	113.7	20.2	179.7	30.4
2	Жирэмсний болон амаржсаны	63.4	90.2	64.6	109.9	64.9	119.3
3	Оршуулгын	13.9	13.9	12.9	12.9	16.2	16.2
4	Эхийн хүүхдээ асрах чөлөөтэй байсан хугацааны шимтгэл	-	-	83.7	2.2	103.7	3.2
<b>Нийт</b>		<b>210.2</b>	<b>124.0*</b>	<b>274.9</b>	<b>145.2*</b>	<b>364.5</b>	<b>169.1*</b>

\* Үйл ажиллагааны болон бусад зардал ороогүй болно.



График 8. Тэтгэмжийн зарлага /тэрбум.төг/



Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.9 тэрбум төгрөг буюу 14.1 хувиар нэмэгдсэн нь КОВИД-19 цар тахлын улмаас өвчлөлийн тоо нэмэгдсэнтэй холбоотой.

**ҮОМШӨ-ний даатгалын сан**

2021 оны жилийн эцсийн байдлаар 5.7 мянган даатгуулагчдад тахир дутуугийн, тэжээгчээ алдсан, ХЧТА, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувиллын зардалд ҮОМШӨ-ний даатгалын сангаас 29.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

Хүснэгт 9. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/

№	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	2019 он		2020 он		2021 он	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Тахир дутуугийн тэтгэвэр	4.0	24.2	3.9	24.8	3.7	24.4
2	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	0.5	2.7	0.5	2.9	0.5	2.9
3	ХЧТА-ны тэтгэмж	1.1	0.7	1.1	0.9	0.7	0.7
4	Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр	0.02	0.02	0.02	0.02	0.01	0.08
5	Рашаан сувиллын зардал	3.2	0.9	2.1	0.6	0.8	0.2
6	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	-	1.0	-	0.7	-	0.7
7	Тахир дутуугийн тэтгэвэр авагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл	-	1.2	-	1.6	-	-
<b>Нийт</b>		<b>8.8</b>	<b>30.8*</b>	<b>7.6</b>	<b>31.5*</b>	<b>5.7</b>	<b>29.0*</b>

\* Үйл ажиллагааны болон бусад зардал ороогүй болно.



График 9. ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага /тэрбум.төг/




ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 2.5 тэрбум төгрөгөөр буурсан.

**Ажилгүйдлийн даатгалын сан**

2021 онд ажилгүйдлийн даатгалын сангаас 26.2 мянган даатгуулагч 57.0 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж авсан байна.

График 10. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн



**3.3.6 Мэдээлэл технологийн үйл ажиллагаа**

НД-ын үйлчилгээг цахимжуулах ажлыг өргөжүүлэх, даатгуулагчдад чирэгдэлгүй шуурхай үйлчлэх зорилтын хүрээнд НД-ын болон тэтгэврийн дэвтрийг цахим хэлбэрт шилжүүлж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн НД-д албан журмаар даатгуулсан 982.2 мянга, сайн дураар даатгуулсан 155.4 мянга, нийтдээ 1137.7 мянган даатгуулагчид QR код бүхий НД-ын цахим дэвтэр, шинээр тэтгэвэр тогтоолгосон 32.7 мянган хүнд тэтгэвэр авагчийн цахим дэвтрийг олгоод байна.



Даатгуулагчийн эмнэлгийн хуудас, ажилгүйдлийн тэтгэмж авах, сайн дурын даатгалд хамрагдаж гэрээ байгуулах, сунгах, төлбөрөө төлөх зэрэг үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, НД-ын салбарт хэрэглэгдэж байгаа нийт 30 төрлийн анхан шатны маягыг бүрэн цахимжуулаад байна.

НД-ын нэгдсэн мэдээллийн санд 51.9 мянган ажил олгогч, 853.5 мянган албан журмын, 152.6 мянган сайн дурын даатгуулагч, 458.4 мянган тэтгэвэр авагчийн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий 74GB мэдээлэл агуулагдаж байгаа бөгөөд тогтмол баяжуулалт хийж, 160 загвараар 210 гаруй удаа мэдээллийн боловсруулалт, судалгаа хийж, хэрэглэгчдийг мэдээллээр хангалаа.

Төрийн 16 байгууллагатай төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан холбогдох мэдээллийг тогтмол солилцож байна.

Азийн хөгжлийн банкны төслөөр хэрэгжүүлж буй НД-ын салбарын мэдээллийн шинэ системийг үе шаттайгаар туршин нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, 2021 оны 11 сараас салбарын хэмжээнд байгууллагын нягтлан бодох бүртгэлийн болон хүний нөөцийн системүүдийн туршилтын ажлыг хийж байна.

### **3.3.7 Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хөгжүүлэлт, хүртээмж**

НД-ын гар утасны аппликейшнийг 207.2 мянган иргэн идэвхтэй хэрэглэж байна. Тайлангийн хугацаанд 2648 иргэнд баталгаажуулалтын нууц дугаарыг цахим хэлбэрээр олгож, утсаар 4790 иргэнд заавар зөвлөгөө өгсөн.

Цахим системээр дамжуулан 151.4 мянган ажил олгогч, давхардсан тоогоор 1.7 сая даатгуулагч шимтгэл төлөлтийн QR код бүхий тодорхойлолтоо үүсгэн ашигласан байна.

Даатгуулагчдад зориулсан вэб хуудсанд нийт 1.7 сая гаруй удаагийн хандалт хийгдэж, 26842 иргэн НД-ын мэдээлэл зөвлөгөөг авсны 501 нь гадаад улс орнуудад ажиллаж байгаа Монгол иргэд байна.

Төрийн үйлчилгээний 109 ТҮЦ машинаас 4 төрлийн лавлагаа тодорхойлолтыг 130.5 мянган иргэн хэвлэн авчээ.

НДЕГ-т цахимаар нийтдээ 5853, үүнээс [www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn) сайтын “Санал хүсэлт” буланд 739 санал хүсэлт, асуулт, “Нийгмийн даатгал” аппликейшнээр дамжуулан 4952 санал хүсэлт, ЗГ-ын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд 162 асуулт ирүүлснийг ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэн хариуг нь өгөв.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн НД-ын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор 3 сарын хугацаатай аяныг зохион байгуулж, 8903 албан бус хөдөлмөр эрхлэгчид сайн дурын даатгуулагчдад НД-ын хууль тогтоомжийг сурталчлах, НД-ын цахим үйлчилгээ, ач холбогдлыг сурталчилан 3196 иргэнийг шинээр сайн дурын даатгалд хамруулсан байна.

### **3.3.8 Эмнэлэг хөдөлмөрийн магадлал**

Улсын хэмжээнд ЭХМТК-оор тогтоогдсон хөдөлмөрийн чадвараа алдсан 105607 иргэн байгаагаас НДС-аас 67141, нийгмийн халамжийн сангаас 38466 иргэн тэтгэвэр, тэтгэмж авч байна. Мөн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоолгосон 7631, сунгуулсан 97976, цуцлуулсан 9926, нас барсан 2728, хөдөлмөрийн нөхцөл сольсон 85, ажлын цаг хорогдуулсан 9 иргэн байна.



Тайлангийн хугацаанд “Даатгуулагч (иргэн)-д хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоосон байдалд хяналт, шалгалт хийх аян”-ыг зохион байгуулж, нийт 63341 даатгуулагч хамрагдсанаас 3742 зөрчил илрүүлэн, 997 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалснаар жилд 4.2 тэрбум төгрөгийг хэмнэж ажилласан.

Баян-Өлгий аймгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүд болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч нарт холбогдох эрүүгийн хэрэгт мөрдөгчийн тогтоолын дагуу шалгалт хийж, хөдөлмөрийн чадвар алдалтыг үндэслэлтэй тогтоосон, сунгасан 126, онош үндэслэлгүй тогтоогдсон 232, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа өөрчлөлттэй 61 даатгуулагч байна гэсэн дүгнэлт гаргалаа. Харин материал бүрдээгүйн улмаас 5 иргэний дүгнэлт гарах боломжгүй байв.

ЗГ-ын 2021 оны 67 дугаар тогтоолоор эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийг шинэчлэн батлууллаа.

### **3.3.9 Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах**

Тайлангийн хугацаанд албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр нийт 951 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 16458 албан хаагчийг хамруулсан байна.

Ажил олгогч, даатгуулагчийн НД-ын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх чиглэлээр 5072 удаагийн сургалтыг явуулж, 6529 аж ахуйн нэгжийн 193969 иргэд, даатгуулагчид оролцов.

НД-ын салбарын хэмжээнд 596 удаагийн явуулын үйлчилгээ, нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, 288543 иргэд, даатгуулагчийг хамруулж, НД-ын талаар мэдээлэл, зөвлөгөө үйлчилгээ өгч ажилласан.

Динамик сургалтын платформыг ашиглан 2544 ажил олгогчдод НД-ын тайланг цахимаар илгээхтэй холбоотойгоор тоон гарын үсэг ашиглах, цахим дэвтэр олгох сургалтыг зохион байгуулж, оролцсон ААНБ-дад тоон гарын үсгийг бүртгэлийн хураамжаас чөлөөлж, олгов.

Хэвлэл мэдээллийн 148 /давхардсан тоогоор/ байгууллагаар дамжуулан 641 удаагийн давтамжтайгаар НД-ын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд, даатгуулагчдад хүргэж, хэвлэл мэдээллийн байгууллагыг эх сурвалж, мэдээллээр хангасан байна.

НД-ын үйлчилгээний талаарх санал хүсэлтийг @sigomongolia, @zmedeelel хуудасны чатботоор хүлээн авч, 37758 иргэнийг мэдээллээр хангаж, 5408 иргэнд тухайлсан зөвлөгөө өгч, 144 гомдлыг шийдвэрлэв.

### **3.3.10 Хяналт шалгалт**

НДҮЗ-ийн 2021 оны 17 дугаар тогтоол, Ажлын албаны даргын 2021 оны А/17 дугаар тушаалын дагуу Ажлын албаны алба хаагчид 2021 оны 10-11 дүгээр сард Нийслэлийн 9 дүүргийн НДХ-үүдэд хууль тогтоомжийн хэрэгжилт, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, цахим үйл ажиллагааны явц, үр дүн, цаашид



авах арга хэмжээ, үйл ажиллагааны санхүүжилтийн байдалтай танилцаж, хяналт шалгалтыг хийсэн.

НД-ын салбарын хэмжээнд төлөвлөгөөт хяналт шалгалтад 609 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдаж, 536 аж ахуйн нэгж, байгууллагад 368.2 сая төгрөгийн торгууль шийтгэвэр ноогдуулснаас 354.0 сая төгрөгийг төлж, барагдууллаа.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг болон Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Увс аймгийн НДХ-үүдэд хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, 4,914.6 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 98.9 хувь нь тэтгэврийн даатгалын сантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хяналт, шалгалтад хамрагдсан НДХ

№	Шалгалтад хамрагдсан аймаг, дүүргийн нэр	Илэрсэн төлбөр, зөрчлийн дүн /сая төг/
1	Архангай аймгийн НДХ	1,507.2
2	Баянхонгор аймгийн НДХ	47.4
3	Увс аймгийн НДХ	1,470.5
4	Говь-Алтай аймгийн НДХ	14.1
5	Сонгинохайрхан дүүргийн НДХ	1,875.4
	<b>Дүн</b>	<b>4,914.6</b>

Улсын хэмжээнд нийт 46.3 мянган ААНБ-ын 739.4 мянган даатгуулагчийн 1,738.7 сая төгрөг, 207.3 мянган сайн дурын даатгуулагчийн 99.7 сая төгрөгийн шимтгэлээс чөлөөлсөн үндэслэлийг аймаг, дүүргийн НДХ-ийн дотоод хяналт, шалгалтаар шалгаж байна. Энэхүү шалгалтаар НД-ын шимтгэлээс чөлөөлөгдсөн, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг авсан 21816 ААНБ-ын 185491 даатгуулагчид олгосон дэмжлэгийг шалгахад 234 даатгуулагчид давхардуулан олгосон 154.4 сая төгрөгийн зөрчил илэрч, уг мөнгийг НДС-д эгүүлэн төлүүлэх арга хэмжээ авлаа.

2020-2021 онд аймаг, дүүргийн НДХ-т хийгдсэн шалгалтаар илэрсэн зөрчилд Улсын байцаагчийн актаар тогтоогдсон торгууль төлбөрийн барагдуулаагүй үлдэгдэл нийт 592.4 сая төгрөг байгаа бөгөөд тайлангийн хугацаанд энэхүү төлбөрийн 27.9 хувь буюу 165.3 сая төгрөгийг барагдуулсан байна.

### **3.3.11 Лавлах үйлчилгээ**

НД-ын “Дуудлагын төв”-д нийт 135681 иргэн хандаж мэдээ, мэдээлэл авсан байна.

НД-ын мэдээллийн цахим сангаас 1502 иргэн, 110 ААНБ цаасан суурьт лавлагааг гаргуулан авсан бол хууль хяналтын байгууллагуудаас ирүүлсэн 689 албан бичгийн дагуу нийт 1691 иргэн, 538 аж ахуйн нэгжтэй холбоотой мэдээлэл лавлагааг гаргаж хүргүүлэв.

### **3.3.12 Гадаад харилцаа, хамтын ажиллагаа**

МУ-д албан ёсоор оршин суудаг, ажил хөдөлмөр эрхэлж байгаа болон эрхэлж байсан ОХУ-ын 77, ОХУ-д албан ёсоор оршин суудаг болон ажиллаж байсан МУ-ын 8, Украин Улсын 1, нийт 86 иргэний материалыг хүлээн авч, ОХУ-ын Тэтгэврийн



фонд, холбогдох газруудад илгээгээд байна. Мөн 121 иргэний ажилласан жилийн тодорхойлолт хүссэн албан бичгийг Монгол-Оросын хамтарсан аж ахуйн нэгж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын сангаас 55 иргэн 133.1 сая вонн нэхэмжилж, 40 иргэн 127.5 сая вонны шимтгэлээ буцаан авсан бөгөөд 10 иргэний нэхэмжлэх шалгагдаж байна. Тайлант хугацаанд БНСУ-д хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээс НДС-д нийт 2.7 тэрбум төгрөгийн НДС-ын шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, НДС-ын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн дагуу 641 сайн дурын даатгуулагчдад 81.2 сая төгрөгийн чөлөөлөлт үзүүллээ. Мөн 752 даатгуулагчийн НДС-ын дэвтрийг баталгаажуулж, 20 даатгуулагчид НДС-ын дэвтэр шинээр олгож, давхардсан тоогоор 15.8 мянган хүнд НДС-ын тухай хууль тогтоомж, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын сангаас буцаан олголт авах талаар мэдээлэл, заавар зөвлөгөө өгч, сурталчиллаа.


МУ-ын 35 иргэн БНУУ-аас 32.5 сая төгрөгийн тэтгэвэр авсны дээр тус улсад ажилласан жилээ баталгаажуулж, өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 6 иргэний тэтгэврийг шинээр тогтоож, 39 иргэний холбогдох материалыг илгээгээд байна.

### 3.4 Дотоод үйл ажиллагаа

#### 3.4.1 Хүний нөөц

Салбарын хэмжээнд батлагдсан орон тоогоор 1436 (100%) ажилтан, албан хаагч ажиллаж байгаагаас санхүү, эдийн засгийн мэргэжилтэй 818 (57.0%), хуульч 66 (4.6%), бусад мэргэжлийн албан хаагч 552 (38.4%) байна.

График 11. НДС-ын албан хаагчдын албан тушаалын ангилал, тоо



НДС-ын салбарт ажиллагсдын 70.9 хувь нь эмэгтэйчүүд, 54.9 хувь нь 40 хүртэлх насны хүмүүс байна.

Хүснэгт 11. НДС-ын албан хаагчдын нас, хүйсийн мэдээлэл


№	Нас	Тоо	Хүйс	Тоо
1	30 хүртэлх	277	Эрэгтэй	417
2	31-40	511	Эмэгтэй	1019
3	41-50	416	-	-
4	51-60	232	-	-



### 3.4.2 Санхүү, төсвийн үйл ажиллагаа

НДБ-ын 2021 оны үйл ажиллагааны зардалд 27.1 тэрбум төгрөг батлагдсанаас 26.6 тэрбум төгрөгийг зарцуулж, 0.5 тэрбум төгрөгийг хэмнэсэн байна. Нийт урсгал зардлын 71.0 хувь буюу 19.0 тэрбум төгрөгийг НД-ын салбарын 1.4 мянган ажилтан, албан хаагчдын цалин хөлс, НД-ын шимтгэлд зарцуулав.

График 12. НДБ-ын үйл ажиллагааны зардал /тэрбум. төг/



### 3.4.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

НД-ын салбарын хэмжээнд Шилэн дансны тухай хууль, ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасны дагуу шилэн дансны цахим хуудсанд НДЕГ, түүний харьяа 33 байгууллага НДС-ийн 31 салбар эрх, нийт 238 хэрэглэгчээр хандан НДС-ийн болон байгууллагын шилэн дансны мэдээллийг төсөв, гүйцэтгэлийн 9, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5, бусад 7, нийт 21 төрлийн мэдээллийг байршуулсан.

НД-ын төв, орон нутгийн байгууллагууд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 10069 мэдээллийг байршуулахаас 10031 мэдээллийг мэдээлж, мэдээлэл байршуулалт 99.6 хувьтай байна. Үүнээс:

- Хугацаанд нь байршуулсан мэдээлэл 9357, биелэлт 92.9%
- Хугацаа хоцроосон мэдээлэл 674, нийт байршуулбал зохих мэдээллийн 6.7%
- Мэдээлээгүй 38, нийт байршуулбал зохих мэдээллийн 0.4%-ийг эзэлж байна.

### ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

НДҮЗ нь системчилсэн үнэлгээнд хамрагдах хугацаанд УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, 2015 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”, ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,



Монгол Улсын хөгжлийн 2021 оны төлөвлөгөө, Нийгмийн даатгалын үйлчилгээний маркетингийн дунд хугацааны хөтөлбөр (2019-2022 он)-ийг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан.

2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг бодлогын баримт бичиг, салбарын үндэсний хөтөлбөр, байгууллагын стратеги төлөвлөгөөний зорилтыг чиглэл болгон 76 ажил үйлчилгээ, арга хэмжээг чиг үүргийн дагуу хийж гүйцэтгэхээр боловсруулсан. Төлөвлөгөөт ажил, үйлчилгээ, арга хэмжээний биелэлт тус бүрт хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэхэд нийт хэрэгжилт 97.9 хувьтай гарсан бөгөөд төлөвлөлт, түүний биелэлт, хэрэгжилтийн байдал байгууллагын төсөв, санхүү, дотоод үйл ажиллагаа “бүрэн хангалттай” үр дүнд хүрсэн байна гэж дүгнэлээ.

Хэрэгжүүлсэн нийт арга хэмжээний зорилт, арга хэмжээ нь зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн 100 хувийн хэрэгжилттэй 66, зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан 90.0-99.4 хувийн хэрэгжилттэй 6, тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, гүйцэтгэл нь 70.0-74.0 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ байна гэж үнэлэгдсэн.

Системчилсэн үнэлгээ хийгдсэн хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, ажил үүргийг зохих түвшинд биелүүлжээ.

Цаашид НД-ын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, НДС-ийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зохицуулалтыг хийж, холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангах, даатгуулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний үр дүнг улам сайжруулах шаардлагатай байна.

## **ТАВ. ЦААШДЫН БОДЛОГО, ЧИГЛЭЛ**

Цаашид НД-ын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан асуудлын хэрэгжилтийг зохион байгуулах, НД-ын багц хуулиудыг боловсронгуй болгон хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2022 онд НД-ын салбарын хэмжээнд дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- НД-ын багц хуулийн шинэчлэлтэй холбогдуулан хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүдийн дагуу дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн батлах, хэрэгжилтийг хангуулах, НД-ын салбарын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг шилэн тунгалаг, авлигаас ангид байлгахад чиглүүлэх;



- Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулинд НДС-д 2.4 их наяд төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, 1 сая орчим даатгуулагчдад 3.3 их наяд төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардалд зарцуулахаар тусгасан бол зөвхөн тэтгэвэрт 3.1 их наяд төгрөгийг олгохоор байна. Энэ их хэмжээний зарлагад тухай бүр хяналт тавих боломж улам бүр хомс болж байгаа тул НД-ын салбарт бүтцийн өөрчлөлт хийж, хяналтыг зайнаас тогтмол хийх боломжийг яаралтай бий болгох шаардлагатай байна. Үүнд:

- Авлага, өрийг барагдуулах чиг үүргийг НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газрын Хуримтлалын сан, өрийн удирдлагын хэлтсийг Тамгын газрын Хуулийн хэлтсийн үйл ажиллагаатай уялдуулан шинээр зохион байгуулах;
  - Эрсдэлийг урьдчилан тооцоолох, хянах, цэгэн хяналтыг үр дүнтэй хийх зорилгоор НДЕГ-ын Дотоод аудит, мониторингийн газарт Эрсдэлийн удирдлагын нэгжийг байгуулах;
  - НДЕГ-ын Хяналт шалгалтын газрын бүтцийг өргөжүүлэн цахим хяналтын нэгжийг байгуулж зайнаас хяналт тавих;
  - Бүх төрлийн тэтгэврийн өргөдөл, материалыг цахимаар хүлээн авах системийг бэлэн болгож, ашиглаж эхлэх, ажил олгогч, даатгуулагч нарт НД-ын үйлчилгээг сурталчлах, цахим үйлчилгээг тайлбарлан таниулах ажлыг бүх түвшинд өргөн хүрээтэй зохион байгуулах, хамралтыг нэмэгдүүлэх, цахимжуулалтын ажилтай холбоотой дотоод хяналт шалгалтыг сайжруулах;
- “Нийгмийн даатгалын мэдээллийн системийг хөгжүүлэх” төслийн хүрээнд НДБ-ын болон сангийн санхүүгийн системийг бүрэн цахимжуулах, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;
- Core системийг 2022 оны эхний хагас жилд багтаан туршиж, ашиглаж эхлэх, энэ системийг ашиглахтай холбоотойгоор сургалтыг бүх түвшинд хийх, сумдын байцаагч нарыг скайнер бүхий хувилагч, найдвартай интернет сүлжээ, компьютерээр хангах;
- НД-ын шимтгэлээр төвлөрүүлэх орлогын хэмжээ 2021 онтой харьцуулахад 575.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн учраас орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд онцгой анхаарч ажиллах;
- НДС-ийн хөрөнгийг найдвартай оновчтой удирдах, мөнгөн хөрөнгийн хөрвөх чадвар, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангаж эрсдэлийг бууруулах зорилгоор сангийн хөрөнгийг арвижуулахад удирдлагаар ханган, үр ашгийг өсгөн нэмэгдүүлэх, хууль эрх зүйн боломжийг бүрдүүлэн ажиллах, Төрийн санд хуримтлуулсан хөрөнгийг өгөөжтэй болгох, эрсдэлийн удирдлагын чадавх, бүтцийг хөгжүүлэх;
- НД-ын үйлчилгээг даатгуулагч, ажил олгогчид илүү хүртээмжтэй, ээлтэй болгох, даатгуулагчдын санхүүгийн хуримтлалыг дэмжсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулан бүрэн цахимжуулах;



- Ажил олгогчоос авах 344.3 тэрбум төгрөгийн НД-ын шимтгэлийн авлагыг барагдуулах, хуримтлагдсан авлагыг бууруулах ажлыг эрчимжүүлэх, ялангуяа төсвийн байгууллагын хувьд шимтгэлийн өр авлага үүсгэхгүй ажиллах, үр дүнг олон нийтэд ил тод мэдээлж байх;
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, төсвийн сахилгыг мөрдөж ажиллах;
- НДБ-д Ёс зүйн хороо байгуулан нийгмийн хариуцлагатай байгууллага болон хөгжихөд анхаарч ажиллах.

Эдгээр зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлсэнээр НД-ын хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдаж, иргэд, даатгуулагчид, ажил олгогчид үзүүлэх НД-ын үйлчилгээ улам сайжирна.

**ЗУРГАА. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН АКТЫН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**

Хүснэгт 12. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт  
/2021 оны жилийн эцсийн байдлаар/

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц
<b>НЭГ. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</b>		
1	2021.02.17 №42  “Төлөвлөгөө батлах тухай” “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 /арван/ их наядын цогц төлөвлөгөө”	Ковид-19 цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурсан боловч ажлын байраа хадгалж байгаа ААНБ, тэдгээрт ажиллаж байгаа даатгуулагчийг дэмжих чиглэлээр ЗГ-аас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллалаа. Уг хуульд УИХ-аас 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх зорилгоор 2021 оны А/34 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журмыг хэрэгжүүлэх заавар” болон хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 11 төрлийн түр маягтын загварыг шинэчлэн батлав. Энэхүү хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 38.9 мянган ажил олгогч, 410.7 мянган албан журмын даатгуулагч, 169.2 мянган сайн дурын даатгуулагчийг хамруулж, нийт 873.9 тэрбум төгрөгийн НД-ын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг үзүүлсэн байна. Мөн ажилгүйдлийн даатгалын сангаас 7.3 мянган аж ахуйн нэгжийн 80.9 мянган даатгуулагчид (давхардсан тоогоор) 44.1 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн болно.



		<p>2021 оны 01-04 дүгээр сарын байдлаар нийт 36.7 мянган ААНБ, 497.4 мянган даатгуулагч, үүнээс 101.2 мянган сайн дураар даатгуулагч нийтдээ 99.3 тэрбум төгрөгийн НД-ын шимтгэлийн чөлөөлөлт, хөнгөлөлтөд хамрагдсан байна.</p>
2	<p align="center">2021.02.17 №43</p> <p align="center">“Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”</p>	<p>Сангийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн тушаалын дагуу НДБ-уудын үйл ажиллагааны урсгал зардлын 2021 оны төсвийн сар, улирлын хуваарьт нийт 10 ангиллын зардлын төсөвт өөрчлөлт оруулсан.</p> <p>Бичиг хэрэг, хэлтсийн албан хэрэгцээний тээвэр шатахуун, сумдын байцаагчдад олгох тээвэр, шатахуун, шуудан, холбоо, интернетийн төлбөр, хог хаягдал зайлуулах, устгал, ариутгал, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс, багаж, техник хэрэгсэл, урсгал засвар зэргийн зардлуудын төсвийг хойш татаж хэмнэлт үүсгэн 12 дугаар сарын төсөвт хуваарилсан бөгөөд НДБ-ын урсгал үйл ажиллагаанд 27.1 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвлөснөөс 26.6 тэрбум төгрөг зарцуулж 2021 оны жилийн эцсийн байдлаар 0.5 тэрбумын хэмнэлттэй ажилласан байна.</p>
3	<p align="center">2021.02.21 №45</p> <p align="center">“Журам батлах тухай”</p> <p>“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”</p>	<p>ЗГ-аас баталсан уг журмын хүрээнд НДЕГ-ын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/27, 03 дугаар сарын 09-ний өдрийн А/36, 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/49, 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/52, 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/62, 06 дугаар сарын 16-ны өдрийн А/82 дугаар тушаалаар ажилтан, албан хаагчдын ажиллах цагийн хуваарь болон хариуцлагатай жижүүрийн ажиллах цагийн хуваарийг тухай бүр шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.</p>
4	<p align="center">2021.03.17 №67</p> <p align="center">“Дүрэм шинэчлэн батлах тухай” “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”</p>	<p>ЗГ-ын 2015 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ЭХМТК-ын дарга, гишүүд ажиллан, СЯ, ХЗДХЯ, ЭМЯ зэрэг холбогдох яамд, төрийн болон төрийн бус байгууллагуудаас дүрмийн төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж, ЗГ-ын хурлаар “Дүрэм шинэчлэн батлах тухай” тогтоолын төслийг хэлэлцүүлж, 2021 оны 67 дугаар тогтоолоор “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс”-ын дүрмийг шинэчлэн батлуулав.</p> <p>Энэхүү дүрэм шинэчлэн батлагдсантай холбогдуулан аймаг, дүүргийн НДХ-ийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дарга нарт “Тогтоол хүргүүлэх тухай” чиглэл болон</p>



		<p>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт салбар болон орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах “Санал ирүүлэх тухай” албан бичгийг хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Мөн Сэтгэцийн болон Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар комисс, аймаг, дүүргийн НДХ-ийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дарга, магадлагч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмч нар болон шинээр томилогдсон гишүүдэд цахим сургалтыг 8 удаа зохион байгуулав.</p> <p>Тус сургалтаар “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-д орсон өөрчлөлтийн талаар болон хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох үйл явц, эмнэлэг хөдөлмөр магадлалын өнөөгийн байдлын талаар танилцуулж, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэхтэй холбоотой асуудлаар мэдээ, мэдээлэл өгч, цаашид анхаарах асуудлын талаар хэлэлцэв.</p>
5	<p align="center">2021.03.24 №70</p> <p align="center">“Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай”</p>	<p>2021 оны хугацаанд 6 удаа худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж худалдан авах гэрээг байгуулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 23.1 сая төгрөг</li> <li>2. Жирэмсэн амаржсаны эмнэлгийн хуудас хэвлэн нийлүүлэх 11 сая төгрөг</li> <li>3. ХЧТА-ийн эмнэлгийн хуудсыг хэвлэн нийлүүлэх 19.9 сая төгрөг</li> <li>4. ХЧТА-ийн эмнэлгийн хуудсыг хэвлэн нийлүүлэх 19.8 сая төгрөг</li> <li>5. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоосон акт, ЭХМТК-н шийдвэрийн наалт 19.8 сая төгрөг</li> <li>6. Тэтгэврийн хувийн хэргийн хавтас, МУ-н тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ хэвлүүлэхэд 11.1 сая төгрөг</li> </ol> <p>Худалдан авсан маягт материалыг бүртгэл тооцоонд бүрэн тусгуулж хэрэгжилтийг ханган ажиллав. 2021 оны худалдан авах үйл ажиллагаа цаг хугацаандаа бүрэн хэрэгжлээ.</p>
6	<p align="center">2021.04.08 №93</p>	<p>ЗГ-аас 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт</p>



	<p>“Коронавируст халдварын цар тахлын үед Монгол Улсын иргэдэд мөнгөн дэмжлэг олгох тухай”</p>	<p>үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж байгаатай холбогдуулан иргэдийг вакцинжуулах, тэдний орлого, дархлааг дэмжих зорилгоор иргэн бүрт 300.000 төгрөгийн мөнгөн дэмжлэгийг нэг удаа олгох тухай 93 дугаар тогтоолын дагуу НДЕГ нь тэтгэвэр авагчдын банканд дахь харилцах дансны мэдээллийг гаргаж өгөх үүрэг хүлээж хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Нийт тэтгэвэр авагчдын НДС дахь мэдээллийг СЯ-ны Төрийн сангийн газарт хүргүүлсэн.</li> <li>2. Өндөр насны тэтгэвэр авагч 459542, тахир дутуугийн тэтгэвэр авагч 70448, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 25424 иргэний болон асран хамгаалагчийн харилцах дансны мэдээллийг Монголбанк болон арилжааны 7 банк /Хаан банк, Төрийн банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк, Капитрон банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк/-аас гаргуулж нэгтгэн "Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв" Улсын төсөвт үйлдвэрийн газарт хүргүүлсэн.</li> <li>3. Дээрх тэтгэвэр авагчдын мэдээллийг Иргэний бүртгэлийн мэдээллийн сангаас тулган СЯ-д хүргүүлсэн.</li> <li>4. Мөнгөн дэмжлэгт хамрагдаж чадаагүй 112 (2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар) иргэний санал гомдол, хүсэлтийг хүлээн авч ebarimt.mn цахим үйлчилгээнээс мэдээллийг тодруулан гүйлгээ буцсан болон мэдээлэл зөрүүтэйгээс гүйлгээ хийгээгүй 25 тэтгэвэр авагчийн мэдээллийг "Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв" Улсын төсөвт үйлдвэрийн газарт хүргүүлэн дэмжлэгийг шилжүүлэх боломжийг бүрдүүлэн ажиллалаа.</li> </ol>
7	<p align="center">2021.04.28 №109</p> <p align="center">“Журам батлах тухай”</p> <p>“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”</p>	<p>“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн аймаг /нийслэл/, дүүргийн НД-ын /газар/ хэлтсийн удирдлагуудад уг журмыг мөрдөж ажиллах талаар чиглэл хүргүүлж ажиллалаа.</p> <p>Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн Дотоод аудит, мониторингийн газрын 2021 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу НДЕГ-ын даргын баталсан</p>



		<p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийх аудитын удирдамжийн дагуу аудитыг хийж байна. Тус аудитыг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан байгууллага буюу НД-ын төв орон нутгийн байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх;</li> <li>- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.7-д заасан НДС-ийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх;</li> <li>- Хуулийн 8 дугаар зүйлд заасан холбогдох албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага зөвлөмжийг биелүүлсэн эсэх;</li> <li>- Хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэсэн эсэх;</li> <li>- Иргэн, хуулийн этгээдээс хуулийн хэрэгжилттэй холбоотой гомдол, мэдээлэл ирүүлсэн эсэх;</li> </ul>
8	<p align="center">2021.05.05 №115 “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай”</p>	<p>Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан НДЕГ-ын даргын 2021 оны 06 дугаар 16-ны өдрийн А/82 дугаар тушаалаар албан хаагчдыг 30 хүртэл хувиар ажлын байранд ажиллах цагийн хуваарийг шинэчлэн баталж хэрэгжилтийг хангаж ажилласан.</p>
9	<p align="center">2021.09.15 №287 “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”</p>	<p>ЗГ-ын 287 дугаар тогтоолд “Журам батлах тухай” ЗГ-ын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 483 дугаар тогтоолын 2 дахь заалтын “2021” гэснийг “2022” гэж, мөн тогтоолын хавсралтаар баталсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 7.4 дэх заалтыг “7.4. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь энэ журмын 7.2-т заасны дагуу хүлээн авсан “Баталгаажилтын хуудас”-ыг тамга, тэмдгээр баталгаажуулж, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид олгоно.” гэж, 4.1 дэх заалтын “2020 оны 12 дугаар сарын 31-ний” гэснийг “2021 оны 12 дугаар сарын 31-ний” гэж, 9.4 дэх заалтын “2021” гэснийг “2022” гэж тус тус өөрчилсүгэй” гэж заасны дагуу НДЕГ-ын даргын 2021 оны 3/1636 дугаар “Тогтоол хүргүүлэх тухай” албан бичгээр аймаг /нийслэл/, дүүргийн НД-ын /газар/ хэлтсүүдэд зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p>



10	<p align="center">2020.02.04 №50</p> <p align="center">“Журам батлах тухай”</p> <p>Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай</p>	<p>УИХ-аас “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай” хууль 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан. Уг хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тэтгэвэр барьцаалсан зээлийн үлдэгдэлтэй 228587 иргэдийн 694,929.8 сая төгрөгийн зээлийг тэглэсэн.</p> <p>Тэтгэврийн зээлгүй болон нэг сая төгрөг хүртэлх тэтгэврийн зээлтэй иргэдэд олгосон үнэт цаасыг 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн мөнгөжүүлсэн ба 7 банкаар нийт 229277 иргэнд 207.5 тэрбум төгрөгийг олгосон.</p> <p>Үнэт цаас эзэмших эрхтэй тэтгэвэр авагчдаас 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш нас барж, үнэт цаасыг ар гэрийн хүнд нь өвлүүлэх 8538 нас барсан иргэд байснаас тайлант хугацаанд 5043 иргэний ар гэрт 4.7 тэрбум төгрөгийг олгоод байна.</p> <p>Харин хуурамч баримт бичгээр тэтгэвэр тогтоолгосон нь тогтоогдсон, 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө тэтгэвэр нь зогссон, нас барсан, хуулийн үйлчлэлд хамрагдахгүй 294 тэтгэвэр авагчийн үнэт цаасыг аймаг, дүүргийн НДХ-ээс татан авч, эдгээр иргэдэд олгох 267.9 сая төгрөгийг олгохооргүй шийдвэрлэсэн.</p>
11	<p align="center">2020.04.17 №140</p> <p align="center">“Журам батлах тухай”</p> <p>Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам</p>	<p>Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулав. Энэхүү хуульд УИХ-аас 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх чиглэлээр 2021 оны А/34 дүгээр тушаалаар “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журмыг хэрэгжүүлэх заавар” болон хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 11 төрлийн түр маягтын загварыг шинэчлэн баталж, хяналт тавьж ажиллав. Энэхүү хуулийн дагуу 38.9 мянган ажил олгогч, 410.7 мянган албан журмын даатгуулагч, 169.2 мянган сайн дурын даатгуулагч хамрагдаж, нийтдээ 873.9 тэрбум төгрөгийн НД-ын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн. Мөн ажилгүйдлийн даатгалын сангаас 7.3 мянган ажил олгогчийн давхардсан тоогоор 80.9 мянган даатгуулагчид 44.1 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн болно.</p>
12	<p align="center">2020.09.02 №90</p>	<p>ЗГ-аас иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх зорилгоор е-</p>



	Засгийн газрын агентлагийн дарга нарт “Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн талаар авах арга хэмжээний тухай”	<p>mongolia.mn цахим портал хуудсыг нэвтрүүлсэн. Энэхүү порталд НДБ нь иргэд даатгуулагчдыг сайн дурын даатгалд цахимаар хамрагдах боломжийг бүрдүүлж өгсөн. Түүнчлэн e-mongolia.mn цахим порталаар НД-ын дараах 4 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг харах боломжийг бүрдүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажил олгогчийн НД-ын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт</li> <li>- НД-ын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт</li> <li>- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа</li> <li>- Иргэн /даатгуулагч/-д НДС-аас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт</li> <li>- Мөн уг порталаар иргэд даатгуулагч сайн дурын даатгалд цахимаар хамрагдан гэрээ байгуулах, сунгах боломжийг бүрдүүлсэн.</li> </ul>
13	2019.12.30 №483  “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”	<p>УИХ-ын нэгдсэн чуулганы 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль”-ийн хэрэгжих хугацааг 1 жилээр буюу 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл сунган баталсан тул 2021 оны А/31 дүгээр тушаалаар аймаг, дүүргийн НДХ-ийн нөхөн даатгалд хамруулах малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тоо, санд төвлөрүүлэх орлогын 2021 оны төлөвлөгөөг батлан хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>ЗГ-ын 2019 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын дагуу уг журмыг хэрэгжүүлэх зааврыг батлан мөрдүүлж, 2021 оны байдлаар 31.8 мянган малчин, 2.6 мянган хувиараа хөдөлмөр эрхлэгч, нийтдээ 34.4 мянган иргэн 76.4 тэрбум төгрөгийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлсөн байна. Хуулийн үр дүнд нийт 11.9 мянган даатгуулагч тэтгэврээ тогтоолгон 33.0 тэрбум төгрөгийг тэтгэвэрт нь зарцуулаад байна.</p>
<b>ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийн дундаж 98 хувь</b>		
<b>ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ</b>		
1	2021.03.03 №54  “Бүрэлдэхүүн батлах тухай”	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2021-2022 оны улсын хэлэлцээрт ЗГ-ыг төлөөлөн оролцох төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд НДЕГ-ын дарга Д.Зоригт гишүүнээр томилогдон ажилласан.



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

	/Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2021-2022 оны улсын хэлэлцээрт Засгийн газрыг төлөөлөн оролцох төлөөлөгчдийн бүрэлдэхүүн/	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээр нь 2021 оны 05 дугаар сард батлагдсан.
<b>ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийн дундаж 100 хувь</b>		
<b>ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ</b>		
1	2021.02.21 №11  “Иргэд, олон нийттэй харилцах 11-11”-ийн тухай	2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар ЗГ-ын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд НДБ-тай холбоотой 162 асуулт иргэдээс ирүүлсэн байна. Ирүүлсэн асуудлыг агуулгаар ангилвал:  НД-ын дуудлагын төв (7777-1289)-ийн үйлчилгээтэй холбоотой 10, НД-тай холбоотой санал хүсэлт 139, ЭХМТК-той 2, бусад буюу байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй 11 асуудлыг мэдээлсэн байна. Мөн иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд НДБ-ын үйл ажиллагаа, байцаагч ажилтнуудын харилцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой ирүүлсэн асуудлуудыг холбогдох газар, хэлтсийн дарга нарт танилцуулан, шийдвэрлэсэн эсэхэд хяналт тавин ажиллаж байна.
2	2021.03.24 №19  “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай”	2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 1/465 тоот албан бичгээр ХНХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт НДБ-уудад хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2022-2024 оны төсвийн төсөөллийн саналыг хүргүүллээ.  НД-ын төв, орон нутгийн байгууллагуудад хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын зайлшгүй хэрэгцээ шаардлага, судалгааг үндэслэн 2022 онд улсын төсвөөс 32,012.5 сая төгрөг санхүүжүүлэхээр, 2023-2024 онд 2,000.0-2,300.0 сая төгрөгийг Нийгмийн даатгалын тухай багц хуулийн шинэчлэлийн хүрээнд НДС-аас санхүүжүүлэхээр тооцов.  1. Шинээр барих барилга, байгууламжийн зардлын төсвийн талаар: НД-ын төв орон нутгийн байгууллагуудын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 2022-2024 оны төсвийн төсөөллийг Архангай, Баянхонгор, Дорноговь, Төв, Орхон аймгийн НДХ-ийн болон Хан-Уул дүүргийн НДХ-ийн тасгийн байр, архивын барилга шинээр барих, НД-ын албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор орон сууц барихад нийт 22,814.1 сая төгрөг төсөвлөсөн.  2. Барилгын өргөтгөл: НДЕГ-т архивын зориулалттай ерөө байхгүйгээс стандартын шаардлага хангахгүй байгаа, мөн тус газраас иргэд,



	<p>даатгуулагчдад лавлагаа, мэдээллээр үйлчилдэг төвийн өрөөний талбай бага тул иргэд гадаа орчинд хүйтэн, халуун нөхцөлд хүлээх, дараалал үүсч байгаа тул иргэд, даатгуулагчдын тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор НДЕГ-ын өргөтгөл хийх зайлшгүй шаардлагыг үндэслэн 1.0 тэрбум төгрөг зарцуулахаар тооцов.</p> <p>3. Барилгын их засварын зардлын төсвийн талаар: НДБ-ын төв, орон нутгийн зарим байгууллагуудын албан конторын барилгын ашиглалтын норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсвийг үндэслэн барилгын их засварын зардлыг тооцон 2020 оны төсвийн төсөлд тусган СЯ-д хүргүүлсэн боловч батлагдаагүй тул 14 нэгжийн конторын барилгын засварын зардалд 2022 онд нийт 3,467.1 сая төгрөг төсөвлөсөн.</p> <p>4. Тоног төхөөрөмжийн зардлын төсвийн талаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Компьютер тоног төхөөрөмж худалдан авах: НДБ-д мэдээллийн шинэ систем нэвтрүүлж байгаатай холбоотойгоор техник хэрэгсэл, Мэдээллийн технологийн төвийн судалгааг үндэслэн салбарын хэмжээнд техник, технологийн хоцрогдол арилгах, элэгдлийн хугацаа дууссан, НДБ-д зайлшгүй хийх шаардлагатай компьютер, тоног төхөөрөмжийн шинэчлэл, орон тооны нормативын дагуу 35 орон тоо шинээр нэмэгдүүлэх зэрэг (сервер, зөөврийн болон ажлын компьютер, тог баригч, принтер, канон, проектор, сканнер г.м)-ийг үндэслэн нийт 2,852.4 сая төгрөг;</li> <li>- Тавилга, эд хогшил худалдан авах: НД-ын төв, орон нутгийн байгууллагуудаас ирүүлсэн санал болон тавилга, эд хогшлын элэгдлийн хугацаа дууссан, дахин ашиглах боломжгүй болсон, орон тооны нормативын дагуу 35 орон тоо шинээр нэмэгдүүлэх зэрэг зайлшгүй хэрэгцээ, шаардлагыг үндэслэн тавилга эд хогшил худалдан авахаар уг зардлыг орон нутгийн зах зээлийн үнэ ханшаар тооцож албан хэрэгцээнд зориулан 2022 онд нийт 1,183.5 сая төгрөг төсөвлөв.</li> <li>- Тээврийн хэрэгсэл худалдан авах: НД-ын төв, орон нутгийн албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа дуусч, шинээр автомашин худалдан авах зайлшгүй шаардлагатай байгаа албан хэрэгцээнд зориулан 2022 онд нийт 1,472.0 сая төгрөг, нийтдээ тоног, төхөөрөмжийн зардлын 2022 оны төсвийн төсөлд 4,367.8 сая төгрөг төлөвлөв.</li> </ul>
--	--



		<p>5. Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн зардлын төсвийн талаар: НД-ын төв, орон нутгийн байгууллагуудын хэлтсийн барилга шинээр болон өргөтгөл бариулах, сэргээн засварлахад мэргэжлийн байгууллагаар техник эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн ажил хийлгэхэд шаардлагатай 2022 онд нийт 223.4 сая төгрөг төлөвлөв.</p> <p>6. Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах талаар: Ажилтан, албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт болон НДҮЗ-ийн 2013 оны 19 дүгээр тогтоолын дагуу орон сууцны дэмжлэг үзүүлэх /нийгмийн баталгааг хангах/ зардалд 500.0 сая төгрөг төлөвлөв.</p>
3	2021.03.31 №21  “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тухай”	<p>2021 оны жилийн эцсийн байдлаар дээд газраас НДЕГ-т ирүүлсэн ЗГ-ын тогтоол 16, МУ-ын Ерөнхий сайдын захирамж 1, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл 14, НДҮЗ-ийн тогтоол 6, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал шийдвэр 3, бусад хамтарсан тушаал 1 байна. Уг 41 шийдвэрийн 1 шийдвэр 2019 онд гарсан, 5 шийдвэр нь 2020 онд, 2021 онд шинээр хяналтад авсан 35 шийдвэрүүд байна. Дээрх шийдвэрүүдийн хэрэгжилтийг Тамгын газар, Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Санхүү бүртгэлийн газар, ЭХМТК, Мэдээллийн технологийн төвөөс тус тус гаргуулан нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлгэхээр Дотоод аудит, мониторингийн газарт хүргүүлсэн.</p> <p>НД-ын салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2021 оны жилийн эцсийн байдлаар 98.0 хувь буюу “Бүрэн хангалттай” гэж үнэлсэн ба үнэлгээний тайланг ХНХЯ-д хүргүүлсэн.</p>
4	2021.06.01 №33  “Агентлагийн дарга нарт” УИХ-ын 2020 оны 45, 2021 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган, салбарын дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасны дагуу боловсруулах	<p>НДЕГ-ын даргын 2021 оны А/21 дүгээр тушаалаар Стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон ажил үүргийн хуваарийг баталсан. Уг ажлын хүрээнд ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу стратеги төлөвлөгөөг боловсруулах нийтлэг үндэслэл, мандатын шинжилгээ, НДБ-ын алсын хараа, эрхэм зорилго, орчны шинжилгээ, стратегийн зорилго, стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги, стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж байгууллагын бүтцийн уялдаа, зураглалыг боловсруулж, НДЕГ-</p>



		ын 2021 оны 1/1424 дугаар албан бичгээр ХНХЯ-д хүргүүлээд байна.
5	<p align="center">2021.06.08 №34</p> <p>“Агентлагийн дарга нарт” ЗГ-ын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх, төвийн цахим програм хангамжийг бүрэн ашиглах, иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг мэдээлэх, төрийн байгууллагуудыг цахим системд холбох, байгууллага хооронд шилжүүлж буй өргөдөл, гомдлын мэдээллийг системд оруулж байх арга хэмжээ авах</p>	<p>НДЕГ-т 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар нийт 427 өргөдөл, гомдол ирүүлснээс 103 нь НДБ-ын ажилтан, албан хаагчдаас, 324 нь иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол байна. Ирүүлсэн өргөдөл, гомдлыг агуулгаар ангилж үзвэл:</p> <p>Тэтгэвэртэй холбоотой асуудлаар нийт 43. Үүнд:</p> <p>Тэтгэврийн нөхцөлийн талаар 7, малчны тэтгэвэртэй холбоотой 8, тэтгэврийн бодолтыг дахин хянуулах тухай 15, тэтгэвэр шинэчлэн тогтоох тухай 7 асуудлыг шийдвэрлэх</p> <p>Тэтгэмжтэй холбоотой асуудлаар нийт 23. Үүнд:</p> <p>Тэжээгчээ алдсаны тэтгэмжтэй холбоотой 2, жирэмсэн, амаржсаны тэтгэмжтэй холбоотой 4, ажилгүйдлийн тэтгэмжийн талаар 12, тэтгэмж авах тухай 5.</p> <p>НД-ын шимтгэл төлөлттэй холбоотой асуудлаар нийт 24. Үүнд:</p> <p>НД-ын шимтгэл нөхөн тооцуулах тухай 9, НД-ын шимтгэл төлөлтийн лавлагаа хүссэн тухай 3, НД-ын шимтгэл төлөлт шалгуулах тухай 11, НД-ын шимтгэлийн хөнгөлөлт эдлэх тухай 1.</p> <p>НД-тай холбоотой бусад асуудлаар нийт 104. Үүнд:</p> <p>НДХ-ийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 3, НДБ-аас тэтгэвэрт гарсан ахмадуудын тусламж дэмжлэг хүссэн тухай 5, гомдлын шаардлагын зөвлөлд 26, аймаг /нийслэл/, дүүргийн НД-ын /газар/ хэлтсүүдэд чиг үүргийн дагуу шилжүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт 14, ЭХМТК-т ирүүлсэн 50, сайн дурын даатгалтай холбоотой асуудлаар 6 өргөдөл гомдлыг ирүүлсэн байна.</p> <p>Дээрх 427 өргөдөл гомдлоос шийдвэрлэгдсэн 417 бөгөөд хяналтад байгаа 10 өргөдөл, гомдол байгаа нь нэмэлт материал авах шаардлагатай зэрэг шалтгаанаар хянагдаж байна.</p> <p>НДЕГ-т ирүүлсэн өргөдөл гомдлыг холбогдох чиг үүргийн дагуу орон нутгийн НДХ-д шилжүүлэн хяналт тавьж ажиллалаа.</p>
6	<p align="center">2021.06.23 №36</p> <p>“Агентлагийн дарга нарт”</p>	<p>НДЕГ-ын даргын 2021 оны А/21 дүгээр тушаалаар Стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон ажил үүргийн хуваарийг</p>



	<p>УИХ-ын 2020 оны 45, 2021 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган, салбарын дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасны дагуу боловсруулах</p>	<p>баталсан . Уг ажлын хүрээнд ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу стратеги төлөвлөгөөг боловсруулах нийтлэг үндэслэл, мандатын шинжилгээ, НДБ-ын алсын хараа, эрхэм зорилго, орчны шинжилгээ, стратегийн зорилго, стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги, стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж байгууллагын бүтцийн уялдаа, зураглалыг боловсруулж, НДЕГ-ын 2021 оны 1/1424 дугаар албан бичгээр ХНХЯ-д хүргүүлээд байна.</p>
7	<p align="center">2021.09.15 №51</p> <p align="center">“Агентлагийн дарга нарт”</p> <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хянан баталгаажуулалт болон санхүүжилтийн гүйлгээг гүйцэтгэгч нарт олгох явцыг үндэслэлгүйгээр удаашруулж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид учруулж буй хүнд суртлыг таслан зогсоох</p>	<p>Хөрөнгө оруулалтын тайлан мэдээг ХНХЯ-аас ирүүлсэн 2021 оны 4/1733 тоот албан бичгийн дагуу НД-ын төв болон орон нутгийн байгууллагуудаас авч нэгтгэн, ХНХЯ-д хүргүүлсэн. 2021 оны жилийн эцсийн тайлан болон 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Сангийн сайдын батлагдсан журмын дагуу ХНХЯ-д хүргүүлэхээр ажиллаж байна.</p>
8	<p align="center">2021.09.29 №53</p> <p align="center">“Агентлагийн дарга нарт”</p> <p>Монгол Улсын хууль, УИХ-ын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, ЗГ-ын тогтоол, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, Албан даалгавар болон Ерөнхий сайдын захирамж зэрэг үүрэг даалгавар болгосон шийдвэрийн хэрэгжилтийг ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу тогтоосон хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх, 2021 оны хагас жилийн байдлаар хэрэгжилт нь</p>	<p>НДЕГ-ын хяналтад ЗГ-ын тогтоол, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, НДҮЗ-ийн тогтоолын нийт 36 шийдвэрийн 50 заалт байна.</p> <p>Хяналтад байгаа нийт 36 шийдвэрийн 1 шийдвэр нь 2019 онд гарсан, 5 шийдвэр нь 2020 онд, 30 шийдвэр нь 2021 онд шинээр хяналтад авсан заалтууд байна.</p> <p>Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг харуулбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• ЗГ-ын 13 тогтоолын 16 заалтын 14 нь бүрэн хэрэгжиж 98.0%;</li> <li>• Монгол Улсын Ерөнхий сайдын 1 захирамжын 1 заалтын хэрэгжилт 100%;</li> <li>• ЗГ-ын хуралдааны 12 тэмдэглэлийн 15 заалтын 13 нь бүрэн хэрэгжиж 98,0%;</li> <li>• НДҮЗ-ийн 6 тогтоолын 12 заалтын 11 нь бүрэн хэрэгжиж 98,0%;</li> <li>• Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 3 тушаалын 2 нь бүрэн хэрэгжиж 96,0%;</li> <li>• НДЕГ-ын дарга, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 1 тушаал бүрэн хэрэгжиж 100,0 хувийн биелэлттэй байна.</li> </ul> <p>НД-ын салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэрийн</p>



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

	удаашралтай, гүйцэтгэл нь хангалтгүй байгаа үүрэг, даалгаврын шалтгааныг тогтоон, хэрэгжилтийг эрчимжүүлэх, гүйцэтгэлийг сайжруулах	хэрэгжилтийг 2021 оны жилийн эцсийн байдлаар 98.0 хувь буюу “Бүрэн хангалттай” гэж үнэлсэн ба үнэлгээний тайланг ХНХЯ-д хүргүүлсэн.
9	2021.10.13 №55  “Бүх шатны төсвийн захирагч нарт” Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах асуудлыг ирэх оны төсөв батлагдсан даруйд шийдвэрлүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэх, худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг зарлаж 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн дотор зохион байгуулж дууссан байхаар тооцож бэлтгэл ажлыг хангах	2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль”-ийн хоёрдугаар хавсралтын XI.2.2-т НДЕГ-ын байрны эх засварт 250.0 сая төгрөг, XI.2.3-т тоног төхөөрөмж худалдан авахад 50.0 сая төгрөгийг тус тус баталсан байна. 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр тендерийн үнэлгээний хорооны ажлын хэсгийг байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа бөгөөд 2022 оны эхний хагас жилд багтаан тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.
10	2021.10.27 №57  “Агентлагийн дарга нарт” Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор төрийн байгууллагууд шинэ жилийн баяр тэмдэглэхгүй байх нь зүйтэй	Урлаг, соёл, спортын арга хэмжээг 50 хувийн дүүргэлттэйгээр нээсэн хэдий ч тус агентлагийн хэмжээнд урлаг соёл, спортын арга хэмжээ зохион байгуулагдаагүй болно. Шинэ жилийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх чиглэлийн дагуу харьяа аймаг /нийслэл/ дүүргийн НДХ-д баярын арга хэмжээ зохион байгуулахгүй байх талаар 2021 оны 12 дугаар сард зохион байгуулагдсан “Нийгмийн даатгалын удирдах ажилтны сургалт-зөвлөгөөн”-өөр чиглэл хүргүүлэн ажиллалаа.
11	2021.12.01 №62  “Агентлагийн дарга нарт”	Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр НДЕГ-ын даргын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/38 дугаар тушаалаар эмнэлгийн хуудасны бичилт олголтыг цахим хэлбэрт шилжүүлж, ажил олгогч болон даатгуулагчид шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх, түүнд тавих хяналтыг боловсронгуй болгох зорилгоор “Эмнэлгийн хуудас олгох, хянах журам”-ыг баталсан. Тушаалыг



	<p>Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4 дэх хэсэгт заасны дагуу ХЗДХЯ-д хүргүүлж 5169 дугаартай улсын бүртгэлд бүртгүүлсэн.</p> <p>Эрхэлсэн асуудал, чиг үүргийнхээ дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрүүдийг хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан хянан үзэж, холбогдох саналаа ХЗДХЯ-д 2022 оны эхний хагас жилд хүргүүлэхээр ажиллаж байна.</p> <p>2021 оны байдлаар ач холбогдлоо алдаж, дагаж мөрдөхөө больсон, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, ХЗДХЯ-аас хүчингүй болгох дүгнэлт гаргаж ирүүлсэн эрх зүйн акт байхгүй.</p> <p>НД-ын салбарын хэмжээнд хэрэглэж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмуудыг шинэчлэх, хүчингүй болгох, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр одоо ашиглагдаж байгаа хууль, эрх зүйн актуудад дүн, шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>НД-ын салбарын хэмжээнд Захиргааны ерөнхий хуулийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөн хэвшүүлэх, цаашид уг хуультай холбоотой зөрчил дутагдал гаргахгүй ажиллах талаар удирдах ажилтнуудад танилцуулан, гаргасан тохиолдолд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах талаар удирдах ажилтны сургалт, зөвлөгөөний үеэр мэдээлэл хийж ажиллалаа.</p> <p>Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран 700 гаруй албан хаагчдад дараах сургалтуудыг зохион байгуулсан.</p> <p>Аймаг, дүүргийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нийт гишүүдэд Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Zoom сургалт зохион байгуулсан. /200 гаруй албан хаагч хамрагдсан/</p> <p>НДЕГ-ын Сургалт, олон нийт, хамтын ажиллагааны газартай хамтран НД-ын сумдын байцаагчдад ёс зүй, харилцаа хандлагын талаарх сургалтыг зохион байгуулахад хамтран ажилласан. Уг сургалтад НДБ-ын 300 гаруй сумдын байцаагчид хамрагдсан болно.</p> <p>ndaatgal.mn сайт болон Able програмд авлигын талаарх видео шторк гарын авлага 3 удаа байрлуулсан.</p>
--	--



		<p>“Нийгмийн даатгалын салбарын удирдах ажилтны сургалт зөвлөгөө”-нд оролцсон 200 гаруй албан хаагчдад “Ашиг сонирхлын зөрчил, авлига”-ын гэмт хэрэг сэдвээр сургалт зохион байгуулсан.</p>
12	<p align="center">2020.05.20 №32 XIII.2</p> <p>“Төрөөс баримтлах бодлогын баримт бичигт туссан боловч хэрэгжилт хангалтгүй, удаашралтай байгаа ажлуудыг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах”</p>	<p>НД-ын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж УИХ-д өргөн бариад байна. Эдгээр хуулийн төсөлд “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын (2015-2030) үндсэн чиглэлд тусгасан заалт бүрийг тусган боловсруулсан.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд НД-ын тогтолцоо, зарчим, төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, шимтгэл төлөх, НДС бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих, сангийн хөрөнгө оруулалтын удирдлага, мэдээллийн нэгдсэн сан, ХХТАО-ын итгэлцүүр, шимтгэлээс чөлөөлөх, нөхөн төлүүлэх, буцаан олгох, тэтгэврийн даатгалын нэрийн дансыг бүртгэх, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, хуримтлагдсан орлогыг өвлүүлэх, шимтгэлийн өр, хөөн хэлэлцэх хугацааг тогтоох НДС-ийн хэтийн тооцоолол хийх, сангийн эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий мэргэжлийн хороодыг ажиллуулах зэрэг шинэ зохицуулалтыг тусгаад байна.</p> <p>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, ахмад настан бүрт суурь тэтгэвэр олгох, иргэн бүр сайн дурын үндсэн дээр хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд даатгуулж, нэмэгдэл тэтгэвэр авах, тэтгэврийг индексжүүлэн нэмэгдүүлэх, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэвэр бодоход баримтлах ХХТАО-ын дунджийг тооцох хугацаа, олон жил шимтгэл төлсөн даатгуулагчийг урамшуулах, тэтгэврийн насыг нэмэгдүүлж, тэтгэвэрт эрт гарах тохиолдолд тэтгэврийн хэмжээг актуар тооцооллын дагуу бууруулах, тэтгэврийн насыг жил тутамд 3 сараар нэмэгдүүлэх замаар 65 насанд хүргэх, тэтгэвэр бодох хувь хэмжээг шимтгэл төлсөн жил бүрт жигд тооцох, хуваарилалтын тогтолцооноос</p>



	<p>хуримтлалын тогтолцоонд шилжих зэрэг асуудлыг тусгасан болно.</p> <p>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөлд тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгох, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх зэргийг тусгасан. Хуулийн төсөлд бөөрний дутагдал, эрхтэн шилжүүлэх, эрхтний донор болсон даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, ихэр хүүхэд төрүүлсэн эхийн амаржсаны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг ОУХБ-ын стандартад нийцүүлэх, даатгуулагчийг ажилгүй болохоос урьдчилан сэргийлэх, ажлын байранд нь тогтвор, суурьшилтай, урт хугацаанд ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажил олгогчид 5 жилд 1 удаа 10 хувиар шимтгэлийн хөнгөлөлт үзүүлж байсныг сангийн чадавхид үндэслэн 3 жилд нэг удаа 15 хувиар хөнгөлөлт үзүүлэхээр тусгав.</p> <p>Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төсөлд үйлдвэрлэлийн ослын улмаас учирсан хохирлыг арилгах, хэвийн үйл ажиллагааг сэргээх зорилгоор сул зогссон хугацаанд, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтнаа тохирсон ажлын байраар хангасан тохиолдолд шимтгэлийн чөлөөлөлт үзүүлэхээр, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөрийг нэмэгдүүлэх, даатгуулагчид протез, ортопедын үнийг 3 жил тутамд 100 хувиар хариуцах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлсэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулсан ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлтийг 15 хувиар үзүүлэх, мөн даатгуулагч тэтгэвэр, тэтгэмж авах өргөдлөө цахимаар өгөх, үйлчилгээг түргэн шуурхай болгох асуудлууд тусгагдсан.</p> <p>Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл батлагдсанаар МУ-д хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль эрх зүйн орчин бүрдэнэ;</p>
--	---



		<p>Тогтвортой ажил хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ;</p> <p>Хувийн нэмэлт тэтгэвэрт хамрагдсан иргэдийн эрх ашгийг хамгаалах, хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төлбөрийн чадварыг хангах нөхцөл бүрдэнэ;</p> <p>Ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах, хангалттай орлогын эх үүсвэртэй байх боломж бүрдэнэ;</p> <p>Санхүү, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх урт хугацааны сан бий болно;</p> <p>Ажил олгогчоос ажилтныхаа хувийн нэмэлт тэтгэвэрт төлсөн шимтгэлийн хэмжээнд татварын чөлөөлөлт үзүүлснээр ажиллагчдынхаа нийгмийн баталгааг хангах зорилгоор хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоонд хамрагдах сонирхлыг нэмэгдүүлэх зэрэг олон эерэг өөрчлөлт бий болно гэж үзэж байгаа юм.</p>
<b>ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн дундаж 98 хувь</b>		
<b>ДӨРӨВ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ</b>		
1	<p align="center">2021.03.29 №02</p> <p>“Өр төлбөр барагдуулах тухай”</p>	<p>НДҮЗ-ийн 2021 оны “Өр төлбөр барагдуулах тухай” 02 дугаар тогтоолоор КЭХА-аас нэхэмжилсэн сангийн төлбөрт тооцон 67.4 тэрбум төгрөгийн 98 ширхэг хөрөнгө авах зөвшөөрөл олгогдож, холбогдох ажлуудыг зохион байгуулахыг НДЕГ-т даалгасан.</p> <p>НДЕГ нь тогтоолын хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг зохион байгууллаа.</p> <p>1. НДЕГ-ын даргын 2021 оны А/51 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар КЭХА-аас хөрөнгө шилжүүлэн авахтай холбоотой ажлуудыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>2. Өр төлбөрт үл хөдлөх хөрөнгө хүлээн авах, бүртгэж хяналт тавих, дуудлага худалдаа зохион байгуулах, худалдан борлуулах хүртэл хадгалж хамгаалах, аюулгүй байдлыг хангах, шаардлагатай зардлыг төсөвт тусган санхүүжүүлэх, ил тод мэдээлж тайлагнах, борлуулалтын орлогыг тухай бүр НДС-д төвлөрүүлэх үйл ажиллагааг зохицуулсан журмын төслийг боловсруулан бэлтгэлээ.</p> <p>3. КЭХА-аас хөрөнгийн гэрчилгээ, кадастрын зураг, тушаал шийдвэрүүдийг баталгаажуулан авч, Төрийн өмчийн бодлого</p>



	<p>зохицуулалтын газарт холбогдох тайлбар, материалын хамт хүргүүлснээр тус газрын 2021-04-21 өдрийн 7 дугаар хуралдаанаар КЭХА-аас санал болгосон хөрөнгийг хоёр тал тохиролцсоны үндсэн дээр шилжүүлэн авах зөвшөөрөл олгосон.</p> <p>4. Хүлээн авахаар шийдвэр гаргасан 46.1 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 65 ширхэг хөрөнгийг ЭМДЕГ авахаар хүсэлт гаргасан тул КЭХА болон хоёр байгууллагын удирдлагуудын уулзалт зохион байгуулснаар үйлдвэр, үйлчилгээ, оффисын зориулалттай 12 ширхэг хөрөнгийг хамтран эзэмшиж, 53 орон сууцыг тоо ширхэгээр нь 2021.04.28 өдрийн байдлаарх төлбөрийн үлдэгдэл дүнгээс нь хамааруулан хувь тэнцүүлэн хувааж эзэмшихээр тохиролцлоо. Төлбөрийн дүнг хувь тэнцүүлэн хуваах хэмжээг дээрх хугацааны байдлаар хоёр байгууллагын нэхэмжилсэн үлдэгдэл төлбөрийн дүнгээс тооцсон ба НДЕГ 43.29%, ЭМДЕГ 56.71% байна.</p> <p>5. ЭМДЕГ-тай хувааж, хамтран эзэмшиж байгаа хөрөнгүүдийг зохицуулах “Хөрөнгө хуваан авах, хамтран өмчлөх, эзэмших хэлцэл”-ийн төслийг бэлтгэлээ.</p> <p>6. Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2006 оны “Маягт, заавар батлах тухай” 18/03 дугаарын тушаалаар батлагдсан НДС-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтад өөрчлөлт оруулах тушаалын төслийг боловсруулан, шийдвэрлүүлэхээр ХНХЯ-д хүргүүлсэн.</p> <p>7. КЭХА-аас хөрөнгийн дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд НДЕГ-ын төлөөлөл орон ажиллаж байгаа ба 2021 онд зохион байгуулагдсан дуудлага худалдаанд тус газар оролцсоноор 380.0 сая төгрөгийн төлбөр төлөгдсөн. Нийтдээ КЭХА-аас 1 586.7 сая төгрөгийн төлбөрийг шилжүүлээд байна.</p> <p>8. КЭХА-д төлбөрт тооцон хүлээн авах хөрөнгийн жагсаалтыг шинэчлэн, баталгаажуулан хүргүүлэв.</p> <p>9. Эрүүгийн цагдаагийн албаны эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт сонгосон хөрөнгийг битүүмжээс гаргах хүсэлтийг хүргүүлэв.</p> <p>10. Авлигатай тэмцэх газарт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/19, А/94 дүгээр хамтарсан тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн гүйцэтгэсэн ажлын тайланг хүргүүлэв.</p>
--	--



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

		<p>11. ХНХЯ-аас КЭХА-аас НДС-ийн нэхэмжилсэн төлбөрийг барагдуулахтай холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар ЗГ-ын гишүүдэд танилцуулга, ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төслийг боловсруулан ЗГ-ын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p> <p>12. НДҮЗ-ийн 2021 оны 05 сарын 17-ны өдрийн хуралдаанаар тогтоолын хэрэгжилтийг танилцуулсан.</p>
2	<p align="center">2021.05.17 №03</p> <p>“Аудитын албан шаардлага, зөвлөмж хэрэгжүүлэх тухай”</p>	<p>НДҮЗ-ийн 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн “Аудитын албан шаардлага, зөвлөмж хэрэгжүүлэх тухай” 03 дугаар тогтоолын дагуу НДЕГ-ын даргын 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/69 дүгээр тушаал гарч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Уг тушаалд Аудитын газраас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг НДЕГ-ын холбогдох газрууд болон НДБ-д үүрэг болголоо.</p> <p>Мөн ХНХЯ-д Үндэсний аудитын газрын 603/А0110001 дугаар албан шаардлагын хэрэгжилтийг хангах талаарх албан бичгийн хамт хүргүүлэв. Аудитын албан шаардлага, зөвлөмж хэрэгжүүлэх нарийвчилсан ажлын төлөвлөгөө батлан ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлт, мөн акт, албан шаардлагын биелэлтийг нэгтгэн гаргаж хуулийн хугацаанд Үндэсний аудитын газар албан бичиг, нотлох баримтын хамт хүргүүллээ.</p>
3	<p align="center">2021.08.06 №16</p> <p>“ҮОМШӨ-ний даатгалын сангаас санхүүжих сувиллын хувьсах зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”</p>	<p>НДҮЗ-ийн 2021 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувиллын хувьсах зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 16 дугаар тогтоолоор ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээг нэг ор хоногт 60.000 төгрөг байхаар шинэчлэн тогтоов.</p>
4	<p align="center">2021.09.24 №18</p> <p>“Журам батлах тухай” “Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам”</p>	<p>НДҮЗ-ийн 2021 оны “Журам батлах тухай” 18 дугаар тогтоолоор “Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам”-ыг баталж, холбогдох ажлуудыг зохион байгуулахыг НДЕГ-т даалгасан.</p> <p>НДЕГ нь тогтоолын хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:</p> <p>1. Хөрөнгийн түрээсийн гэрээг сунгах, түрээслэх байдлаар харилцагч байгууллага, иргэнд мэдэгдэл хүргүүлэх ажлыг зохион байгуулж, 22</p>



		<p>харилцагчтай түрээсийн гэрээг байгуулан 25.9 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.</p> <p>2. Үл хөдлөх хөрөнгүүдийг борлуулж худалдахаар дуудлага худалдаанд оруулах үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, эхний дуудлага худалдааг 2022 оны 01 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр урилга байршууллаа.</p> <p>3. НДҮЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанд 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан талаар танилцууллаа.</p>
5	<p>2021.09.24 №19</p> <p>“Өр төлбөр барагдуулах тухай”</p>	<p>НДҮЗ-ийн 2021 оны “Өр төлбөр барагдуулах тухай” 19 дүгээр тогтоолоор КЭХА-аас нэхэмжилсэн сангийн төлбөрт тооцон 22.1 тэрбум төгрөгийн 46 ширхэг хөрөнгийг НДС-ийн нэхэмжилсэн өр төлбөрт суутган авах зөвшөөрөл олгогдож, холбогдох ажлуудыг зохион байгуулахыг НДЕГ-т даалгасан. НДЕГ нь тогтоолын хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:</p> <p>1. НДЕГ-т НДҮЗ, ХНХЯ-ны төлөөллийг оруулан хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг байгуулан ажиллаж, дээрх шийдвэрүүдийн дагуу КЭХА-тай “Өр төлбөр барагдуулж, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх гэрээ”-г байгуулан, 22.1 тэрбум төгрөгийн 46 ширхэг хөрөнгийг нэг бүрчлэн үзэж шалган, акт үйлдэн хүлээн авсан.</p> <p>2. Авлигатай тэмцэх газар, Эрүүгийн цагдаагийн албаны эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газар, Нийслэлийн прокурорын газар болон банкны эрх хүлээн авагчид сонгосон хөрөнгийг битүүмжээс гаргах хүсэлтийг хүргүүлсэн.</p> <p>3. Хөрөнгийн түрээсийн гэрээг сунгах, түрээслэх байдлаар 30 харилцагч байгууллага, иргэнд мэдэгдэл хүргүүлж, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж байна.</p> <p>4. Үл хөдлөх хөрөнгүүдийг борлуулж худалдахаар дуудлага худалдаанд оруулах үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, эхний дуудлага худалдааг 2022 оны 01 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд 2021.11.30-ний өдөр урилга байршууллаа.</p> <p>5. Арилжааны банктай хамтран 24 ширхэг 4.9 тэрбум төгрөгийн үнэлгээтэй орон сууцнуудыг банкны ипотекийн болон орон сууцны зээлд</p>



		<p>хамруулан борлуулах ажлыг зохион байгуулан, нийт 5 иргэний зээл авах материал банкинд судлагдаж байна. Эдгээр орон сууцнаас нэг орон сууц 2 орон сууц борлогдон, санд 484.4 сая төгрөг төвлөрөөд байна.</p> <p>6. КЭХА-аас НДС-д 2020 онд 826.7 сая, 2021 онд 7,223.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, мөн “Өр төлбөр барагдуулж, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх гэрээ” байгуулан 22,156.6 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч, нийт 30,206.7 сая төгрөгийн төлбөрийг барагдуулаад байна. Өнөөдрийн байдлаар КЭХА-аас нэхэмжилсэн төлбөрийн үлдэгдэл 73,999.9 сая төгрөг бөгөөд үүнээс ҮОМШӨ даатгалын сан 62,023.0 сая, ажилгүйдлийн даатгалын сан 11,976.9 сая төгрөг байна.</p> <p>7. НДҮЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанд 19 дүгээр тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан талаар танилцууллаа.</p>
6	<p align="center">2020.12.28 №10</p> <p align="center">“2021 оны төсвийн хуваарь батлах тухай”</p>	<p>НДҮЗ-ийн 10 дугаар тогтоол, НДЕГ-ын даргын А/56, А/92, А/102, А/124, А/136 дугаар “2021 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” тушаалын хэрэгжилтийг хангаж, гүйцэтгэлийг сар бүр хянан ажиллав.</p>
<p><b>НДҮЗ-ийн тогтоолын хэрэгжилтийн дундаж 98 хувь</b></p>		
<p><b>ТАВ. САЙДЫН ШИЙДВЭР, ТУШААЛ</b></p>		
1	<p align="center">2021.07.05 №1/1885</p> <p align="center">“Тайлан хүргүүлэх тухай”</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 1/1885 тоот “Тайлан хүргүүлэх тухай” шийдвэрийн дагуу НДБ-ын 2021 оны эхний хагас жилийн биелэлтээс зорилтот түвшиндээ хүрээгүй, хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж ирүүлэх талаар холбогдох газрын дарга нарт үүрэг даалгавар өгсөн. Төлөвлөгөөнд туссан 76 арга хэмжээний бүрэн хэрэгжсэн 44, 90 хувийн биелэлттэй 7, 70 хувийн биелэлттэй 10, 50 хувийн биелэлттэй 2, 30 хувийн биелэлттэй 2, 0 хувийн биелэлттэй 3, хугацаа болоогүй 8 арга хэмжээ байснаас НДЕГ-ын Тамгын газарт:</p> <p>ИСО 9001:2015 олон улсын стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах; Санхүү бүртгэлийн газарт:</p> <p>НДС-ийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулж, нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;</p>



	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/46 дугаар тушаалаар батлагдсан “Маягт заавар батлах тухай” маягтын дагуу бүртгэлийн нэгтгэлийн маягтуудыг НДБ-д хөтлүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;</p> <p>Анхан шатны маягт шинэчлэгдсэнтэй холбоотой холбогдох журам, заавар, зөвлөмж, чиглэлийг боловсруулан батлуулж, төв, орон нутгийн НДБ-ыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах;</p> <p>Бодлогын хэрэгжилт, судалгааны газарт:</p> <p>НД-ын төв, орон нутгийн албадыг НДС-ийн болон үйл ажиллагааны зардлын төсөв, төлөвлөгөө боловсруулах нэгдсэн удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах;</p> <p>НД-ын салбарын статистик үзүүлэлтийн нэгтгэлийг шинэчлэн, нарийвчилсан үзүүлэлтээр баяжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх;</p> <p>ҮСХ-ны даргын 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн тушаалаар баталсан НД-ын салбарын статистикийн мэдээллийн маягтыг ҮСХ-той хамтран шинэчлэн боловсруулах;</p> <p>МУ-ын ЗГ, Бүгд Найрамдах Польш улсын ЗГ хоорондын Нийгмийн хамгааллын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, удирдлагын тохиролцоо, шаардлагатай маягтын санал боловсруулж, ХНХЯ-д хүргүүлж төв, орон нутгийн албадыг мэргэжил, арга зүйгээр ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, гадаад оронд байгаа Монгол иргэдэд сурталчлах</p> <p>МУ, ОХУ-н хооронд НД-ын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг шинэчлэхтэй холбоотой тооцоо, судалгаа хийх, санал боловсруулах;</p> <p>Дотоод аудит, мониторингийн газарт:</p> <p>НДС-ийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангаас мөнгөн хадгаламж байршуулахтай холбогдсон гэрээ, төлбөр тооцоо, хүүгийн хэмжээнд мониторинг хийх, дүгнэлт гаргах</p> <p>Нийгмийн даатгалын хууль болон Зөрчлийн тухай хууль, Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах;</p> <p>ЭХМТК:</p> <p>Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон иргэдийн тоогоор улсын дунджаас өндөр орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд батлагдсан хуваарийн дагуу хяналт шалгалт хийх;</p>
--	--



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

		<p>Мэдээллийн технологийн төвд:</p> <p>Азийн хөгжлийн банкны төслөөр нэвтрүүлэх НД-ын мэдээллийн шинэ системийг турших, нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэгч компанитай хамтран хэрэгжүүлэх;</p> <p>НДС-ийн анхан шатны бүртгэлийн маягтыг цахимжуулахтай холбоотой мэдээллийн технологийн ажил үйлчилгээг хэрэгжүүлэх;</p> <p>Эмнэлгийн хуудсыг цахимжуулах ажлыг хэрэгжүүлэх ажлуудыг тус газрын дарга нар эрчимжүүлэн анхаарч ажиллах талаар үүрэг өгч байгууллагын 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд дээрх ажлуудын хэрэгжилт бүрэн хангагдсан эсэхэд хяналт тавьж, 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 1/2233 тоот албан бичгээр ХНХЯ-д хүргүүлээд байна .</p>
2	<p>2021.07.22 №1/1995</p> <p>“Чиглэл хүргүүлэх тухай” “Үлгэрчилсэн заавар”</p>	<p>Төрийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг тусгуулах, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн Үлгэрчилсэн зааврыг мөрдөж ажиллахыг НДЕГ-ын “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж нийт удирдлага болон ажилтан, албан хаагчдад НДЕГ-ын дотоод сүлжээгээр дамжуулан танилцах чиглэл өгсөн. Мөн 2021 оны 12 дугаар сард зохион байгуулагдсан “НД-ын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн”-өөр аймаг /нийслэл/, дүүргийн НД-ын хэлтсийн удирдлагуудад “Үлгэрчилсэн заавар”-ын талаар мэдээлэл хүргэж, хэлтсийн хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжилтэд анхаарч ажиллах талаар зөвлөлөө.</p>
3	<p>2021.09.30 №А/152</p> <p>“Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай”</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/152 дугаар тушаалыг үндэслэн А/143 дугаар тушаалаар НДЕГ-ын Төрийн захиргааны албан хаагчдаас Ахлах түшмэлийн зэрэг дэв шинээр болон ахиулан олгосон 8 албан хаагч, 27 албан хаагчийн дэс түшмэлийн зэрэг дэвийг ахиулан болон шинээр олгон батлагдсан цалингийн төсөвт багтаан цалингийн хувь хэмжээг шинэчлэн тогтоосон болно.</p>
<b>Сайдын шийдвэр, тушаалын хэрэгжилтийн дундаж 96 хувь</b>		
<b>ЗУРГАА. БУСАД /ХАМТАРСАН ТУШААЛ/</b>		
1	<p>2021.12.02 №33</p> <p>“Акталж данснаас хасах тухай”</p>	<p>НДЕГ-аас 2021 оны 1/1436 албан бичгээр дамжуулан, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/349 дүгээр захирамжийн дагуу Баянгол дүүргийн 19 дүгээр хороо, 4 дүгээр хороололд байрлалтай 2 авто гражийн байрлаж буй газрыг “Бүрд пропертиз”</p>



		<p>ХХК-д олгосон хэсэг, 2014 оны А/992 дугаар захирамжийн дагуу Баянгол дүүргийн 12 дугаар хороонд байрлалтай авто гражийн байрлаж буй газрыг иргэн Д.Энхжаргалд олгосон хэсгийг тус тус хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг Захиргааны хэргийн шүүхэд гаргасан. Захиргааны хэргийн шүүх холбогдох материалуудыг судлан үзэж "...Хөөн хэлэлцэх хугацаа дууссан." гэдэг хариуг ирүүлсэн бөгөөд уг шийдвэрийн дагуу дээрх автогражуудыг акталж, данснаас хасуулах саналыг, мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 33 дугаар хуралдааны тэмдэглэлд дурдсаны дагуу холбогдох нэмэлт тодруулга, тайлбарыг тус газарт хүргүүлэн ажиллалаа.</p>
<p align="center"><b>Бусад тушаал, шийдвэрийн хэрэгжилтийн дундаж 100 хувь</b></p>		<p align="center"><b>НИЙТ ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ 98 хувь</b></p>

**ДОЛОО. УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНООС ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

УИХ-ын НББХ-оос НДС-ийн Капитал банкинд байршуулсан хадгаламжийн хөрөнгийг холбогдох яам, агентлагийн төсвийн эрх захирагч нар шийдвэртэй арга хэмжээ авч буцаан авахыг чиглэл болгосон. Энэ хүрээнд НДҮЗ-өөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

1. НДҮЗ 2021 оны “Өр төлбөр барагдуулах тухай” 19, 24 дүгээр тогтоол баталж, КЭХА-аас нэхэмжилсэн сангийн төлбөрт хөрөнгө тооцон авах зөвшөөрөл олгож, холбогдох арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг НДЕГ-т үүрэг болгож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Мөн 18 дугаар тогтоолоор “Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам”-ыг гаргаж, НДС-ийн авлага, өр төлбөрт үл хөдлөх хөрөнгийг авах, эргэлтийн хөрөнгийг ашиглах замаар сангийн авлагыг барагдуулах эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

2. НДС-ийн төлбөрт хүлээн авсан хөрөнгүүдийг Авлигатай тэмцэх газар, Эрүүгийн цагдаагийн албанаас битүүмжилсэн байсныг Нийслэлийн прокурорын зөвшөөрлөөр цуцлуулж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт шилжсэн бөгөөд тэдгээр хөрөнгүүдийг НДБ-ын нэр дээр бүртгэх ажлууд хийгдэж байна. Үүнд: 46 объектын 22.1 тэрбум төгрөгийн үнэлгээтэй хөрөнгийг хүлээн авсан.

3. Үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байсан аж ахуйн нэгж, иргэнтэй түрээсийн гэрээг шинэчлэн байгуулж, 2021 онд 22 аж ахуйн нэгж, иргэнээс 25.9, 2022 онд 24 аж ахуйн нэгж, иргэнээс 38.3, нийт 64.2 сая төгрөгийн түрээсийн орлогыг НДС-д төвлөрүүллээ.

4. Орон нутагт байрлалтай 5.2 тэрбум төгрөгийн 12 ширхэг хөрөнгийн дуудлага худалдаа зохион байгуулж, 8 ширхэг хөрөнгийг худалдан борлуулж, санд 3.1 тэрбум төгрөг орууллаа.



5. Нийт 4.9 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 24 ширхэг орон сууцыг ХААН банкны зээлд хамруулж, 15 байрны орон сууцны зээл авах материал банканд судлагдаж, 2 ажилтны зээлийн шийдвэр гарсан бөгөөд хоёр орон сууц бэлэн мөнгөөр борлогдон, санд 484.4 сая төгрөг төвлөрөөд байна.

6. НДЕГ, ЭМДЕГ-ын хамтран авсан нийт 11.9 тэрбум төгрөгийн 10 ширхэг хөрөнгийн дуудлага худалдаа зохион байгуулах бэлтгэл ажлууд хангагдаад байна.

7. КЭХА-аас НДС-д 2020 онд 826.7 сая, 2021 онд 7,223.3 сая, 2022 онд 200.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, мөн “Өр төлбөр барагдуулж, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх гэрээ” байгуулан 22,156.6 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч, нийт 30,406.6 сая төгрөгийн төлбөрийг барагдуулаад байна. Өнөөдрийн байдлаар КЭХА-аас нэхэмжилсэн төлбөрийн үлдэгдэл 73,799.9 сая төгрөг бөгөөд үүнээс ҮОМШӨ-ний даатгалын сан 62,023.0 сая, ажилгүйдлийн даатгалын сан 11,776.9 сая төгрөг байна.

2022 оны 02 дугаар сарын 28-ны байдлаар арилжааны 11 банкинд 595.9 тэрбум төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй, төрийн санд 174.8 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 13. НДС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, тэрбум.төг  
/2022 оны 02 дугаар сарын 28-ны байдлаар/

№	Банкны нэр	Харилцахын үлдэгдэл	Нийт дүн
1	Голомт банк	19.2	19.2
2	Капитрон банк	55.1	55.1
3	Төрийн банк	194.9	194.9
4	Төрийн сан	174.8	174.8
5	Хаан банк	205.2	205.2
6	Хас банк	1.9	1.9
7	Худалдаа хөгжлийн банк	19.7	19.7
8	Тээвэр хөгжлийн банк	0.39	0.39
9	Солонгос Үрий банк	0.07	0.07
10	Чингис хаан банк	99.5	99.5
11	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	0.01	0.01
	<b>Нийт дүн</b>	<b>770.7</b>	<b>770.7</b>
12	Капитал банкнаас авах авлага	73.8	73.8

**Үндэсний хөрөнгө оруулалтын банк**

Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-т заасан “..... хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлэх” шаардлагыг 2019 оны 10 дугаар сараас эхлэн хангахгүй болсон.

Тус банканд НДС-ийн мөнгөн хөрөнгө 2021 оны эхний байдлаар 5.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тухайн жилд харилцах дансанд өмнөх оны болон тухайн оны харилцах дансны хүү 454.0 сая төгрөг, харилцах данснаас 5.82 тэрбум төгрөгийн төлбөрийг 2021 онд барагдуулсан.

2022 оны 02 дугаар сарын 28-ны байдлаар 12.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.



**Чингис хаан банк**

Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-т заасан “..... хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлэх” шаардлагыг 2019 оны 10 дугаар сараас эхлэн хангахгүй болсон.

Тус банканд НДС-ийн мөнгөн хөрөнгө 2021 оны эхний байдлаар 101.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд тухайн жилд 1.0 тэрбум төгрөг, харилцах дансанд 23.3 сая төгрөг хүү бодогдож, 2022 онд 1.0 тэрбум төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан.

2022 оны 02 дугаар сарын 28-ны байдлаар 99.52 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2020 оны 09 дүгээр сард Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд НДС-ийн мөнгөн хөрөнгийг гаргуулах тухай нэхэмжлэл гарган, 2020.10.22 өдрийн 181/ШШ2020/02624 дугаар шүүгчийн захирамжаар нэхэмжлэлийг бүрэн хангаж шийдвэрлэсэн.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
АЖЛЫН АЛБА